

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,
СУМДЫН 2023 ОНЫ 05 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.06.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

Зөвлөн туслах ажлын хүрээнд:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын жилийн үйл ажиллагааны төлөвлөлт

2.Хүний нөөцийн бэхжилт

3.Хурлын худалдаан болон Зөвлөлийн Хурлын баримт материалын бүрдүүлэлт

4.Хурлын хороодын ажил байдал

5.БИНХ-ын үйл ажиллагаа

6.Сумын ГХУСАЗСЗ-ийн ажил байдал

7.Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж ажиллаж буй байдал

8.Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байдал

9.ХАСХОМ-ийн тайлан мэдээ, баталгааны маягт, мэдэгдэл тайлбарыг архивын нэгж болгосон байдал

10.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах

11.Хурлын төсөв санхүүгийн байдал

12.Шаардлагатай бол сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн гишүүд, Бодлогын хороодын дарга нартай уулзалт хийж мэдээлэл өгөх зэрэг чиглэлээр ажиллана. Энэ удаагийн зөвлөн туслах ажилд тус сумаас сонгогдсон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Сэлэнгэсайхан оролцож байна.

Сэлэнгэ аймагтаа гадаад хэл, хүний хөгжлийн чиглэлээр олон жил үр дүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа “Туж” хөгжлийн төв, АНУ-ын “Лидершифт Импакт” байгууллага, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албатай хамтран аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, Ажлын албаны ажилтнууд, Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдэд зориулан “Үнэ цэнтэй удирдагчийг бэлтгэх нь” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Сургалтаар манлайллын үндэс, нийгмийн баримжаа, үнэ цэн алсын хараа, үр дүнтэй манлайлах болон инновац, урам зориг зэрэг хувь хүний хөгжлийн мэдлэг мэдээллийг хүргэлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа Цагдаагийн ерөнхий газрын Экологийн Цагдаагийн албаны дарга, цагдаагийн хурандаа М.Батсайхан, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Энх-Од нарыг хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр аймгийн Цагдаагийн газрын ажил байдлын талаар болон аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг

зохицуулах салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар санал солилцож, цаашид хамтран ажиллах ажлын талаар ярилцлаа.

Сэлэнгэ аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, Сүхбаатар сумын болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанаас хэлмэгдэгсдийн үр хүүхэд төрөл төрөгсөдтэй хамтран хэлмэгдэгсдийн дурсгалд зориулан мод тарилаа.

Аймгийн төв Партизаны талбайн урд Цэцэрлэгт хүрээлэнд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан ногоон төгөл байгуулах ажлын хүрээнд нарс, тэхийн шээг, хайлаас зэрэг 100 ширхэг тарьц суулгацыг тарилаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга асан, Хурлын ахмад ажилтан О.Буянтогтохыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа хүлээн авч уулзан хүндэтгэл үзүүллээ. Учир нь О.Буянтогтох нь Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын 30 жилийн түүхийг эмхэтгэн “Сэлэнгэ аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагуудын түүх 30 жил” номыг бичиглэсэн бөгөөд энэхүү номд нутгийн өөрөө удирдах ёсны үүсэл хөгжлөөс эхлээд түүхийн улбаа, Сэлэнгэ аймгийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын түүхэн дараалал, голлох чухал шийдвэрүүд зэрэг 1992 оноос хойших эдүгээг хүртэлх Сэлэнгэ аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллагын бүхий л түүхэн товчооныг агуулсан байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс тус аймгийн хэмжээнд сургуулийн өмнөх насны хүүхэд, эцэг эхчүүдэд замын хөдөлгөөнд оролцох зөв дадал олгох, хэвшүүлэх, зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль, дүрмийн мэдлэгийг сурталчлах зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой-2023" тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 12 цэцэрлэгийн 120 хүүхэд, 24 багш сурган хүмүүжүүлэгч, 44 эцэг эх, асран хамгаалагч амжилттай оролцож багийн дүнгээр:

- ТЭРГҮҮН байранд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгийн “Цагдаагийн жавхаа” баг,
- ДЭД байранд Сайхан сумын 3 дугаар цэцэрлэгийн “Ирээдүйн эзэд” баг,
- ГУТГААР байранд Сайхан сумын 2 дугаар цэцэрлэгийн “Жавхаа” баг тус тус шалгарлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа аймгийн Ахмадын хорооны Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзлаа. Аймгийн Ахмадын хорооноос сүүлийн үеийн ажил байдлаа товч танилцуулж, удахгүй зохион байгуулах ажил арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгч, тулгамдаж буй асуудлуудын талаар ярилцаж санал солилцлоо.

Орхонтуул сумын Ерөнхий боловсролын сургуулийн Д.Сүхбаатар багштай 7 дугаар ангийн сурагчид аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, Нутгийн удирдлагын ордонтой танилцах хүсэлт ирүүлсний дагуу ангийн багш, сурагчид, эцэг эхийн төлөөллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа хүлээн авч уулзан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтэц, үйл ажиллагааг танилцуулан мэдээлэл өгч, Нутгийн удирдлагын ордонтой танилцууллаа.

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа аймгийн төвийн Ерөнхий боловсролын сургуулиудаас сурлага, урлаг, спортын

амжилт гарган амжилттай суралцаж байгаа сурагчдын төлөөлөл болох 40 хүүхдийг Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан хүлээн авч уулзлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын зүгээс хүүхэд багачууддаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүтэц, үйл ажиллагааны талаар танилцуулан хүүхдүүдийн санал хүсэлтийг сонсож, амжилттай сайн суралцаж байгаад нь ТАЛАРХАЛ дэвшүүлж, гарын бэлэг гардуулан цаашдын сурах их үйлсэд нь амжилт хүслээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймаг “Гадаад харилцааг эдийн засагжуулах” нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж хөтөлбөрийн хүрээнд олон улс оронтой салбар бүрд амжилттай хамтран ажиллаж байгаагийн нэг нь ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улс юм.

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж Буриад Улсад 4 удаагийн албан айлчлалыг хийж боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуйн салбарт үр дүнтэй хамтран ажиллаж байна. Аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржийн урилгаар ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын тэргүүн Алексей Самбуевич Цыденов 100 гаруй албаны төлөөллийн хамт өргөн бүрэлдэхүүнтэйгээр манай аймагт айлчилж, Алтанбулаг суманд байрлах зөвлөлтийн дайчдын хөшөөнд цэцэг өргөж хүндэтгэл үзүүлэн, аймгийн нэгдсэн Музейг үзэж сонирхлоо.

Айлчлалын хүрээнд Буриад улсын 100 жилийн ойд зориулан Тужийн нарсанд 1 га газарт мод тарьж “ОХУ-ын Бүгд найрамдах Буриад Улсын Тэргүүний нэрэмжит төгөл”-ийг байгууллаа. Мөн ОХУ-ын БНБУ-ын Мал эмнэлгийн газар, Сэлэнгэ аймгийн Мал эмнэлгийн газартай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурлаа. Мөн ОХУ-ын Бүгд найрамдах Буриад Улсын аж ахуйн нэгжүүдийн жимс, жимсгэнийн тарьц суулгацын худалдаа явагдаж, урлагийн байгууллагуудын тоглолтыг Сэлэнгэ аймгийн иргэдэд толилууллаа.

ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын тэргүүн Алексей Самбуевич Цыденов тэргүүтэй албаны төлөөлөгчид Сүхбаатар сумын Улсын тэргүүний Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай танилцаж, ахлах ангийн сурагчидтай уулзлаа. Уулзалтын үеэр тус сургуулийн сурагчдыг эцэг эхийн хамт Буриад улсад айлчлахыг урьж, Буриадын Их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцах боломж байгааг илэрхийллээ.

ОХУ-ын “Газопровод Союз Восток” ХХК-ий төлөөлөл манай аймагт ажиллаж, Тужийн нарсанд мод тарилаа. Тус аж ахуйн нэгжийн зүгээс аймгийн нутаг дэвсгэрт олон нийтийн эдэлбэр газрыг моджуулах арга хэмжээнд 7 сая төгрөгийн хамтын ажиллагааны гэрээг үзэглэлээ.

Мөн “Газопровод Союз Восток” ХХК нь РЦНК буюу Оросын Шинжлэх Ухаан, Соёлын төвтэй хамтран ирэх 9 дүгээр сард Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Төв зэрэг хойд бүсийн аймгуудын сурагчдын дунд орос хэлний олимпиадыг Сэлэнгэ аймагт зохион байгуулахаар болсон бөгөөд шалгарсан сурагчдад 100 хувийн тэтгэлгээр ОХУ-д суралцах эрх олгохоор боллоо. Мөн Томск хотын Политехникийн Их Сургуульд инженер техникийн чиглэлээр, Красноярск хотын Их сургуульд ХАА-н чиглэлээр оюутан элсүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийллээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар үндэсний хэмжээнд хэрэгжиж буй “Тэрбум мод” хөтөлбөр, арга хэмжээнд манай аймаг голлох үүрэгтэйгээр оролцож байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаагаар

ахлуулсан баг бүрэлдэхүүн “Модны тарьц, суулгац нийлүүлэгч аймаг болох” зорилтын хүрээнд Дорноговь аймагт ажиллаж, 5-7 настай, 6 нэр төрлийн 300 ширхэг модны суулгацыг аймгийн төв болон тус аймагт шинээр байгуулагдсан 6 дугаар сургуулийн талбайд тарьж, тарих аргачлал, арчилж ургуулах талаарх мэргэжил арга зүйн заавар зөвлөгөөг өгч хамтран ажиллалаа.

Манай аймаг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая ширхэг тарьц суулгац тарихаар гэрээ байгуулан “Тарьц, суулгац нийлүүлэгч аймаг” байх зорилтын хүрээнд 1497 га талбайд 3,7 сая ширхэг мод тарьж, 3,2 сая ширхэг тарьц суулгацыг зах зээлд нийлүүлээд байна.

УИХ-ын гишүүн Ч.Ундрамын ажлын алба болон Эмэгтэйчүүдийн “Бриллиант клуб” ТББ-ын Сэлэнгэ салбар хамтран “Мэдлэг Монголын баялаг” сэдэвт эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг 1000 эмэгтэйчүүдийн дунд нэгдсэн арга хэмжээг Сүхбаатар, Мандал сумдад зохион байгуулаа. Уг арга хэмжээгээр эмэгтэйчүүд нийгмийн бүхий л салбарт манлайлагч байх, өөртөө итгэлтэй, өөртөө хайртай байх арга зүйн сургалтууд, урлаг, соёлын, бизнесийн арга хэмжээнүүд явагдлаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Боловсролын судалгаа арга зүйн чадвар төв” төрийн бус байгууллагатай хамтран “ЭЕРЭГ ХАНДЛАГА, АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ” сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн төвийн төр төсвийн байгууллагын 400 гаруй алба хаагчид хамрагдлаа.

Төрийн албаны ерөнхий шалгалтын 2-р улирлын Сэлэнгэ аймагт шалгалт өгөхөөр 149 иргэн бүртгүүлсэн ба 5 ээлжээр 124 иргэн шалгалтад орж, 53 иргэн тэнцлээ.

Аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “ДӨЛ-2023” цогцолбор тэмцээн зохион байгуулагдаж шилдгүүдээ тодрууллаа. Тэмцээн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд 3 үе шаттайгаар зохион байгуулагдсан бөгөөд нийт 1750 гаруй сурагчид, 30 гаруй багш, ажилчид, 250 гаруй төрийн албан хаагчид, 500 орчим эцэг эхчүүдийг хамруулсан өргөн цар хүрээтэй нөлөөллийн арга хэмжээ боллоо.

Тэмцээний гарааны өмнөх ажиллагаа “Жагсаалын үзүүлэх тоглолт”, “Гардан тулааны үзүүлэх тоглолт”, “Галын бэлтгэлийн норматив”, “Тасгийн захирагч”, “Асуулт хариулт”, “Эсээ” бичлэг, “Гэрийн даалгавар” гэсэн 7 төрлөөр, 6 км замыг туулсан “Энхийн төлөө” марш гүйлт, гүйлтийн явцад “Гранат шидэлт”, “Буудлага”, “Тактикийн ажиллагаа”, “Эмнэлгийн норматив”, “Цэргийн байр зүй”, “Химийн норматив” гэсэн 6 цэг дээр өгөгдсөн дасгалыг хийж гүйцэтгэсэн.

- Тэмцээнд бүс бүсээсээ шалгарсан шигшээ 10 багийн тамирчид өрсөлдөж
- “Тэргүүн” байрыг П.Сэлэнгэ захиралтай Б.Тэмүүжин захирагчтай Мандал сумын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн “Сүлд” тасаг,
 - “Дэд” байрыг С.Тулга захиралтай, Ж.Энх-Амгалан захирагчтай Мандал ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн “Хөх чоно” тасаг,
 - “Гутгаар” байрыг Р.Цолмон захиралтай Г.Алтан-Эрдэнэ захирагчтай Мандал ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн “Билиг” тасаг,
 - “Тусгай” байрыг Ц.Уранбодол захиралтай Б.Сансар захирагчтай Зүүнбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн “Сүлд” тасаг,
 - “Тусгай” байрыг Н.Даваажаргал захирагчтай Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн “Шонхор” тасаг тус тус эзэллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоол, 2023 оны мн/209 дүгээр тогтоол, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2022 оны н/67 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/179 дүгээр захирамжийг тус тус үндэслэн хугацаат цэргийн албаны 2023 оны ээлжит цэрэг татлагыг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад бүсчлэн зохион байгуулж явуулсан.

Сэлэнгэ аймгаас 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаар тэнцэж Хилийн цэргийн ангиудад цэргийн албаа амжилттай хааж халагдан ирсэн дайчдыг орон нутагт нь угтан авах арга хэмжээг тус аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Цэргийн штабын офицерууд болон халагдан ирсэн дайчид тэдний ар гэрийн төлөөлөл оролцлоо.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Тайлангийн хугацаанд ой, хээрийн түймрийн 1, объектын гал түймрийн 15, мал, амьтны гоц халдварт өвчний 3, зам тээврийн осол 1 нийт 20 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар гарч иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 210 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймэр, гамшиг ослын аюулаас авран хамгаалсан байна.

Стратегийн команд штабын сургууль ирэх 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулагдахтай холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдлын үзлэгийг 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулж, үзлэгийн дараа стратегийн команд штабын сургуулийн танилцуулга, танхимын сургалтыг явуулсан.

Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан “Бэлэн бай” нөлөөллийн аяны хүрээнд аймгийн Нутгийн удирдлагын ордон, Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Статистикийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар зэрэг байгууллагын гэрлийн унтраагуур, цаг бүртгэлийн систем, ариун цэврийн өрөөнд “Бэлэн бай” постеруудыг байршуулж, мэдээлэл өгч ажилласан.

Сүхбаатар сумын Партизаны талбайн урд хэсэгт байрлах лед дэлгэцээр Онцгой байдлын ерөнхий газраас бэлтгэсэн видео сэрэмжлүүлгийг иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Алтанбулаг сумын Б.Ринчений нэрэмжит ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн 330 гаруй сурагчдад “Газар хөдлөлт” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад хамрагдсан сурагчдын дунд асуулт, хариултын тэмцээн зохион байгууллаа.

Улаанбаатар Төмөр замын дохиолол холбооны 1-р ангийн Сүхбаатар холбооны ажилчдад аймгийн Улаан Загалмайн хороотой хамтран “Газар хөдлөлт”, “Анхны тусламж” сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

Стратегийн команд штабын сургууль болохтой холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 5-12 дугаар ангийн 200 гаруй сурагчдад “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах” сэдвээр сургалт зохион байгуулсан.

Төрийн болон төрийн бус аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн барилга байгууламжийн 8 ажлын зургийг хянаж Онцгой байдлын газрын даргаар баталгаажуулан дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэн 400.000 төгрөгийн хураамжийг аймгийн төрийн сангийн дансанд тушаалгаж ажилласан.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Монгол Улсад хэмжил зүйн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан тус хэлтэст 1980-2001 онуудад сорилт шинжилгээ, хэмжил зүйн шалгалт баталгаажуулалтад ашиглаж байсан 3 нэр төрлийн хэмжих хэрэгслүүдийг аймгийн Нэгдсэн музейн сан хөмрөгт хүлээлгэн өглөө.

Үйлчилгээний баталгаажуулалтаар Мандал, Цагааннуур, Зүүнбүрэн, Түшиг, Баянгол сумдын аж ахуйн нэгж, иргэний үйлчилгээний газрыг тохирлын үнэлгээнд хамруулж “MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, “MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” стандартад нийцсэн 16 үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Экспорт баталгаажуулалтаар Ерөө суманд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс” ХХК-уудын олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал-MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 43 удаагийн тээвэрлэлтэд баталгаажуулалт хийж экспортын гэрчилгээ олгосон.

Бүтээгдэхүүний баталгаажуулалтаар Мандал сумын 1-р багт үйл ажиллагаа явуулдаг иргэн Э.Золзаяагийн “Заяат” талхан цехэд тохирлын үнэлгээнд хамруулж “MNS 4664:2009 Талх, талхан бүтээгдэхүүн. Техникийн ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцсэн нэг нэрийн 1 төрлийн буриад талханд баталгаажуулалт хийж гэрчилгээ олгосон.

Стандарт, мэдээллийн салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага иргэний захиалгын дагуу 6 нэрийн 6 стандартаар хангаж 3 аж ахуйн нэгж байгууллага, иргэд 3 нэр төрлийн 3 стандартын борлуулалт хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг Сайхан, Баруунбүрэн, Сант, Орхонтуул, Орхон, Хушаат, Алтанбулаг, Сүхбаатар сумдад ээлжит баталгаажуулалтаар ажиллаж 36 шатахуун түгээх газрын 71 шатахуун түгээгүүрийг, 1 иргэний 4 усны тоолуурыг шалган баталгаажуулсан.

Шалган тохируулгаар: 4 байгууллагын 5 хэмжих хэрэгсэл /мерник, сүмбэнметр, шингэний тоолуур/-д шалгалт тохируулгын гэрчилгээ олгосон.

Массын хэмжлээр: Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг, Сайхан, Баруунбүрэн, Сант, Орхонтуул, Орхон, Хушаат, Алтанбулаг, Сүхбаатар сумдын 87 жин, 7 термометр баталгаажуулсан.

Цахилгаан хэмжлийн төрлөөр: 115 ширхэг цахилгааны тоолуур баталгаажуулж, 2 цусны даралтын аппарат, 2 автоклавын монометрийг тус тус баталгаажуулсан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 34 аж ахуй нэгжийн 93 дээжид 396 үзүүлэлтээр сорьцын шинжилгээ хийж 1,106,400 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

5 сард 939 баримтаар 10,3 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 4 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн вэб сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран иргэд олон нийт, зохицуулалтын байгууллагуудад зориулсан сургалт хэлэлцүүлэг, “Санхүүгийн зах зээл нээлттэй өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Арга хэмжээнд арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, даатгал, брокер, хувьцаат компаниуд, Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцооны төв оролцон үйл ажиллагаагаа иргэд олон нийтэд танилцууллаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		32,435,610.4	15,240,541.5	47.0
	Орон нутгийн төсвийн орлого	17,727,384.9	13,795,749.3	77.8
1.1	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	7,936,636.0	1,457,045.6	18.4
	Сумдын төсвийн орлого	9,790,748.9	12,338,703.7	126.0
1.2	Сумдаас авах орлогын шилжүүлэг	359,100.0	200,000.0	55.7
1.3	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	400,000.0	-	-
1.4	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	3,747,998.1	-	-
1.5	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	-	-	-
1.6	Төсөвт байгууллагын өөрийн орлого	636,267.9	-	-
1.7	Сум хөгжүүлэх сангийн орлого	860,239.7	-	-
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		47,294,956.9	22,686,050.3	48.0
	Орон нутгийн төсвийн нийт зарлага	47,294,956.9	22,686,050.3	48.0
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	27,441,336.8	13,975,913.4	50.9
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	5,699,588.3	423,253.0	7.4
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	14,154,031.8	8,286,883.9	58.5
2.1	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,454,554.8	20,000.0	1.3
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	2,942,538.2	319,954.4	10.9
	Халамжийн сан	40,824.0	31,219.0	76.5
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	9,394,614.8	7,607,573.4	81.0
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	321,500	308,137.1	95.8
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		779,561.8	779,561.8	100.0
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	779,561.8	779,561.8	100.0
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	-	-	-

	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	-	-	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	-
	Усан хангамжийн татаас	-	-	-
4. Тусгай сангуудын зарлага		1,742,804.1	355,156.1	20.4
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,742,804.1	355,156.1	20.4

2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – IV	2023 – IV	<u>2023 - IV</u> <u>2022 - IV</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа	1 500	2 200	146.7
	Гурил /Алтантариа, I зэрэг, кг/	1 500	2 200	146.7
	Талх /орон нутгийн, ш/	1 400	2 000	142.9
	Нарийн боов /кг/	4 300	5 500	127.9
	Будаа /кг/	3 200	3 600	112.5
	Элсэн чихэр /кг/	3 200	3 500	109.4
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	9 500	9 500	100.0
	Үхрийн мах /кг/	12 000	12 500	104.2
	Адууны мах /кг/	8 500	8 500	100.0
	Ямааны мах /кг/	9 000	8 000	94.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	12500	18500	148.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	2 700	3 700	137.0
	Сүү / савласан, л/	3 800	4 800	126.3
	Тараг /задгай, л/	2 500		
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	21 000	25 000	119.0
	Айраг /л/	5 000		
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	5 500	8 500	154.5
	Өндөг /ш/	400	500	125.0
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	8 100	11 500	142.0
	Өөхөн тос /кг/	3 500	3 000	85.7
	Шар тос /кг/	25 000	25 000	100.0
	Масло /задгай, кг/	6 000	11 000	183.3
5	ХҮНСНИЙ НОГОО			

Төмс /кг/	1 200	1 500	125.0
Лууван /кг/	2 500	2 000	80.0
Манжин /кг/	2 500	2 500	100.0
Байцаа /кг/	2 800	2 500	89.3
Сонгино /кг/	2 500	3 000	120.0
Өргөст хэмх /шилтэй, дарсан/	6 000	7 500	125.0
Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	4 000	6 200	155.0
2. ШАТАХУУН			
Бензин А - 80	2 350	2 480	105.5
Бензин А - 92	2 400	2 500	104.2
Дизелийн түлш	2 840	3 910	137.7

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Монголын Хуульчдын холбоо нь Ерөнхийлөгчийн тушаалаар жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн про боно өдөр” болгон зарласантай холбогдуулан “ПРО БОНО-2023” өдөрлөгийг зохион байгуулж Монголын Хуульчдын холбооны Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл, Шүүхийн тамгын газар, Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Өмгөөлөгчдийн холбоо, Нотариатчидын танхим, Хүний эрхийн Үндэсний комисс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар хамтран оролцож, үйл ажиллагаагаа танилцуулж, нийт 110 иргэдэд үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгч, 11 байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 14 шторк, видеог лед дэлгэцээр иргэдэд сурталчилсан.

Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын даргаас баталсан удирдамжийн дагуу сумдын төрийн албан хаагч, иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээх, урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр явуулах арга барилд сургах үүднээс Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, Хүний эрх хамгаалагчийн тогтолцоо сэдвээр Хүдэр, Ерөө, Баянгол, Мандал сум болон тус сумын 413, 433 дугаар хорих ангид хууль зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулж 740 иргэнийг хамруулсан.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын улсын байцаагчийн актаар хураасан 12 ширхэг загасыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан эд зүйлийг устгах комисс аймгийн нэгдсэн хогийн цэгт устгах ажлыг зохион байгуулсан.

Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендерийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонсогч” мэдлэг олгох сургалтыг ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 11 дүгээр ангийн сурагчдыг хамруулан зохион байгуулсан.

Авлигатай тэмцэх газраас “Шүгэл үлээх ажиллагаа”-ны хүрээнд зохион байгуулж буй “Нэгдье” авлигын эсрэг аяныг улс орон даяар нэгэн зэрэг өрнүүлж байгаатай холбогдуулан холбогдох мэдээллийг сум агентлагуудад хүргүүлэн, ажиллаж байна.

Архивын тасаг: “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Архивын ерөнхий газартай хамтран 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022” стандартын талаарх онолын мэдлэг болон монгол бичгийн программ дээр ажиллах, дадлага олгох сургалтыг зохион байгууллаа. Сургалтад аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албад, сумдын Засаг даргын Тамгын газрууд болон сумдын төрийн байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнууд зэрэг нийт 180 гаруй ажилтнууд оролцлоо.

ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын Засгийн газрын тэргүүн Цыденов Алескей Самбуевич Засгийн газрын төлөөлөгчдийн хамтаар Сэлэнгэ аймагт албан ёсны айлчлалын хүрээнд тус улсын Архивын газар, Төрийн архив хамтарсан үзэсгэлэн зохион байгуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн Биеийн тамир, спортын газар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг сумын Засаг даргын Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтын мөрөөр улсын байцаагчийн албан шаардлага, дүгнэлтийг гарган хүргүүлсэн.

Мөн шалгалтын үеэр сумдын Засаг даргын Тамгын газар болон төр төсвийн байгууллагуудын ажилтнуудад “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, “Баримт бичгийн стандарт”, “Байгууллагын архивын зохион байгуулалт”, “Хадгаламжийн нэгж бүрдүүлэх”, “Архивын баримтад тооллого хийх” тухай сургалтыг зохион байгуулж сургалтад 44 албан хаагч оролцсон.

Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сумдын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагууд, Хушаат сумын Эрүүл мэндийн төв, аймгийн Татварын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын улсын байцаагчдын албан хэрэгцээнд ашиглаж буй хэвлэмэл хуудсуудыг хянаж заавар, зөвлөгөө өгсөн.

Цагдаагийн газар: 2023 оны 5 дугаар сард аймгийн хэмжээнд нийт 2489 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 852 буюу 52.1 хувиар өссөн, үүнээс гэмт хэргийн шинжтэй 682 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 65 буюу 10.5 хувиар өссөн бол Зөрчлийн 1807 гомдол мэдээлэл бүртгэгдэж урд оны мөн үеэс 787 буюу 77.1 хувиар өссөн.

Нийт 293 гэмт хэрэг бүртгэгдэж, урьд оны мөн үеэс -56 буюу 16.0 хувиар буурсан бол нийт 23266 зөрчил бүртгэгдэж урьд оны мөн үеэс 10792 буюу 86.5 хувиар өссөн байна.

Шүүхийн шинжилгээний алба: Тус сард гэмт хэргийн дуудлага өссөн дүнгээр нийт 163, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ 312, криминалистикийн 47, магадлан шинжилгээ 49, тусгай шинжилгээ 65 хийж ажилласан.

Улсын бүртгэлийн хэлтэс: “Цахим үндэстэн-Цахим тоон гарын үсэг” аяны хүрээнд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын гаргасан удирдамжийн дагуу “Явуулын баг” ажиллаж 16 насанд хүрсэн сурагчдад тоон гарын үсэг олголоо.

Иргэний бүртгэлийн талаар

- Төрсний бүртгэл - 128 /эрэгтэй - 63, эмэгтэй - 65/
- Гэрлэлтийн бүртгэл - 31
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 8

- Үрчлэлт - 3
- Эцэг, эх тогтоолт - 03 /үүнээс эрэгтэй - 3, эмэгтэй - 0/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 6
- Нас баралт - 43
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 361
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 116
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 62
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 183
- Гадаад паспорт олголт - 495
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн - 78 /үүнээс насанд хүрсэн 46, хүүхэд 32
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 99 тус тус бүртгэгдсэн байна.
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар
- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 996
- Анхны бүртгэл - 192
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 207
- Барьцааны гэрээ - 533
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 28
- Лавлагаа хуулбар - 17
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 397
- Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн

талаар

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 984
- Анхны бүртгэл- 35
- Өмчлөх эрх шилжих гэрээ-141
- Барьцааны гэрээ- 772
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 18
- Лавлагаа хуулбар-03
- Нийт бичигдсэн гэрчилгээ-187

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Сүхбаатар сумын Улсын тэргүүний Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр 45 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Лингафоны танхим” байгуулахаар боллоо.

Ази тивийн физикийн олимпиад манай улсад зохион байгуулагдахтай холбогдуулан ерөнхий боловсролын сургуулийн физикийн багш, сурагчдын дунд зохион байгуулагдаж байгаа “Мэдлэгийн квант түгээе” аяны хүрээнд Сэлэнгэ аймагт физик, танин мэдэхүйн өдөрлөгийг зохион байгуулж, Шинжлэх Ухааны Академийн эрдэмтэн, докторууд, ерөнхий боловсролын сургуулийн 30 багш, физикт сонирхолтой, танин мэдэхүйн лекц, туршилт сонирхож буй 10-12-р ангийн 170 гаруй сурагчид оролцсон бөгөөд “Орчлон ертөнцөөр аялъя”, “Байгалийн цацраг идэвхийг хэмжье”, “Цахилгаан соронзон индукцийн үзэгдэл”, “Оптикийн туршилт”, “Лазерын туршилт”, “Хурдан галт тэрэг”, “Стейм туршилт”, “Танин мэдэхүйн кино” зэрэг 7 танхимуудаар аялан хамрагдлаа.

Монгол Улсын Боловсролын Их сургууль, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний дагуу физикийн хичээлийн цахилгаан, электроникийн туршилтад хичээлийн цогц багаж, ардино-электрон байгууламжуудыг зохион бүтээх хэрэглэгдэхүүнүүдийг 6 сургуульд гардуулан өгч, физикийн багш нарт сургалт зохион байгуулсан.

ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Засгийн газрын тэргүүн А.С.Цыденовын урилгаар аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтантуяа, ерөнхий боловсролын сургуулийн 11 болон 12 дугаар ангийн суралцагчид, тэдгээрийн эцэг, эхчүүд, захирал, багш нар нийт 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр Буриад Улсын Улаан-Үд хотноо айлчилж тус улсын их дээд сургууль, коллежтой танилцлаа.

Соёл урлагийн байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулийн номын сангууд, эвент танхим, томоохон сүм хийдэд нийт 64 объектод эрсдэлийн үнэлгээг хийж ажиллалаа.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд” арга хэмжээг Сэлэнгэ аймгийн хэмжээнд 3 дахь удаагаа зохион байгууллаа. Энэхүү баярын арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ч. Ундрам, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н. Лхагвадорж, Нийгмийн бодлогын хэлтэстэй хамтран зохион байгууллаа. Номын баярын хүрээнд 1 сургалт, 9 төрлийн уралдаан, 11 ажил арга хэмжээ зохион байгуулж 695 иргэд олон нийт хамрагдсан.

Аймгийн Нийтийн номын сантай хамтран “Алдаагүй, зөв сайхан бичигтэн, зөв тод уншигч шалгаруулах уралдаан”-ыг зохион байгууллаа. “Үндэсний бичиг, соёл, номын өдрүүд” арга хэмжээнд Сайхан сумын 2-р сургуулийн Ш.Ариунаа багштай 10а ангийн “Уран бичлэгийн үзэсгэлэн” гарган хамтран оролцсон.

Аймгийн түвшинд EGRA, EGMA арга зүйг хэрэгжүүлсэн сайн туршлагуудаас харилцан судлах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “Унших /EGRA/ ба тоо бодох /EGMA/ чадварыг хөгжүүлэх арга зүйн харилцан туршлага судлах, суралцах” нь сэдэвт аймгийн бага ангийн багш нарын зөвлөгөөн боллоо. Зөвлөгөөнд 17 сум 6 тосгоны ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн багш нар болон бага боловсрол хариуцсан сургалтын менежерүүд, мэргэжилтнүүд нийт 420 хүн хамрагдлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар “Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, “Эерэг хандлага-Ээлтэй нийгэм”, “Цаг гаргая” аян, Эрүүл мэндийн яамнаас дэвшүүлсэн “Энэ жилдээ-эрүүл жиндээ” аяны хүрээнд зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар таргалалтыг бууруулахын тулд Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарын нийт эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, ажилчдын дунд **“Таван хан уулаараа овоглосон эрүүл мэндийнхэн”** сэдэвт урлаг, спортын олон төрөлт тэмцээн, ажил мэргэжлийн уралдааныг зохион байгууллаа. Арга хэмжээнд 340 гаруй эрүүл мэндийн албан хаагч, спортын 7 төрлөөр /сагсан бөмбөг, волейбол, дартс, шатар, даам, сурын харваа, ажлын байрны дасгал/ шилдгүүдээ тодрууллаа.

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн нэрэмжит “Аваргын гараа-2023” өсвөр үеийн үндэсний бөхийн барилдаан 17 дахь удаагаа зохион байгуулагдаж, тэмцээнд /Алтанбулаг, Шаамар, Баруунбүрэн, Жавхлант, Зүүнбүрэн, Цагааннуур, Сүхбаатар/ сумдын 7 сургуулийн Ерөнхий боловсролын

сургуулийн бага нас, дунд нас, ахлах насны ангиллын нийт 88 сурагчид хурд хүч, авхаалж самбаагаа уралдуулан өрсөлдлөө.

Монголын Дугуйн Холбоо, Номадик дугуйн клубын хамтран зохион байгуулсан Уулын дугуйн аварга шалгаруулах бартаат замын 25 км-ын “Морь хурдан уу, Дугуй хурдан уу” тэмцээнд Дугуйтай Сэлэнгэ клубын 27 дугуйчин аймгаа төлөөлөн амжилттай оролцлоо. Тус тэмцээнд 36 байгууллагын 279 дугуйчин оролцсон юм.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын харьяат, Үндэсний шигшээ баг, Сүлд спорт хороо, “Blue dragon” компаний тамирчин Лхагватоогогийн ЭНХРИЙЛЭН дэлхийн аварга шалгаруулах тэмцээний 57 кг жинд хүрэл медаль хүртэж дэлхийн аварга шалгаруулах тэмцээний хос хүрэл медальтан боллоо.

Эрүүл мэндийн талаар: Хугацаат цэргийн албаны 2023 оны нэгдүгээр ээлжийн эрүүл мэндийн үзлэгийг Мандал, Сайхан, Сүхбаатар сумдад бүсчлэн аймгийн Цэргийн штаб, Сүхбаатар, Мандал, Сайхан сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Сайхан сумын Эрүүл мэндийн төв, “Эмнэх баг”, “Номтхан”, “Хараа манал”, “Ачит амирлуулагч”, “Үйлст эмнэхүй” Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгууллаа. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан цэргийн насны залуучууд нь нийт 14 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг, 3 төрлийн оношилгоо, 5 төрлийн шинжилгээнд тус тус хамрагдсан бөгөөд нийт 1039 залуучууд хамрагдсанаас 30 хувь нь эрүүл мэндээр тэнцсэн нь өмнөх татлагаас 1,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд халамжийн санд улсын төсвөөс 65621 иргэнд 20938900.8 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 194 иргэнд 34472.0 мянган төгрөгийг олгоод байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн сан EJOB программд баяжилт хийж:
- Ажил олгогчийн мэдээлэл - 35
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд - 129 иргэн
- Идэвхтэй ажил хайгчаар - 159 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд - 111 иргэн
- Сул чөлөөтэй - 112 ажлын байр
- Шинээр бий болсон 89 ажлын байрыг бүртгэж мэдээлсэн байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас “Ажлын байрны өдөрлөг” арга хэмжээг зохион байгууллаа. Тус өдөрлөг нь ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны зарыг иргэдэд нээлттэй зарлах, ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хайгч иргэдэд хөдөлмөрийн зах зээлийн мэдлэг олгох, ажилгүй иргэдийг ажил олгогчтой холбон зуучлах, зөвлөгөө өгөх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд бүртгэх болон төсөл хөтөлбөрт хамрагдсан иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүр тогтмол зохион байгуулагддаг юм.

Энэ удаагийн өдөрлөгт Сэлэнгэ МСҮТ, Шаамар МСҮТ, “Болд төмөр ерөө гол” ХХК, “Илч Хужирт” ХХК, “Эсмон констракшн” ХХК “болон аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, 17 сум 6 тосгоноос Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчид 23 ажил олгогч байгууллагаас ирүүлсэн 470 ажлын байрыг иргэдэд нээлттэй мэдээлж, 400 гаруй ажил хайгч иргэн ажил олгогчтой уулзалт ярилцлагад орж, мэдээлэл зөвлөгөө авснаас эхний шатны ярилцлагад 130 иргэн тэнцсэн байна.

Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүгийн дэмжлэг авсан 63 иргэний бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, 8801.5 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг зарж борлуулан, иргэдийн орлогыг дэмжин ажиллалаа.

Сэлэнгэ МСҮТ, Шаамар МСҮТ-үүд нь байгууллагын үйл ажиллагаагаа олон нийтэд танилцуулан, суралцагч, төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг сурталчлах, суралцагсдын бүтээлийн үзэсгэлэн гаргах, худалдан борлуулж идэвхтэй оролцлоо.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж 236 иргэнийг хамруулж ХЭДС-аас 511335.0 мянган төгрөг зарцуулсан.

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь Улсын Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 4,591,065,500.00 төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 18,399,201.94 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл оруулах төлөвлөгөөтэйгөөс 2-р улирлын гүйцэтгэлээр 17,853,776.74 мянган төгрөг хуримтлуулж төлөвлөгөөний биелэлт 97,04 хувьтай байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 18833 тэтгэвэр авагчдад 41,295,484.00 мянган төгрөгийг, тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 1739 хүнд 282,555.44 жирэмсэн болон амаржсаны 449 хүнд 885,906.00 оршуулгын 167 хүнд 362,000.00 мянган төгрөгийн тэтгэмж олгосон.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 183 даатгуулагчид 1,455,939.15 мянган төгрөгийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн ослын тэтгэмж, сувиллын зардалд олгосон.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 243 даатгуулагчдад 826,127.80 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг хугацаанд нь олгож ажилласан олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс нь суурин 4 удаа хуралдаж нийт 300 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 46 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 233 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 18 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Нүүдлийн хурлыг Баянгол, Мандал суманд зохион байгуулж 127 иргэн даатгуулагчид эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйлчилгээ үзүүлж 1 иргэнд шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоож 120 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг сунгаж 4 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ хугацааг цуцалсан байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: “Ирээдүйн эзэд-2023” арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны газар болон Монголын оюутны холбоотой хамтран зохион байгуулж, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11, 12 дугаар ангийн сурагчид, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудыг хамрууллаа. Арга хэмжээний хүрээнд оюутан сурагчдад сайн дурын ажил болон

цагийн ажил, их дээд сургуулиудын хөтөлбөр мөн оюутан болоход шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөмжүүдийг өгч ажиллалаа.

“Тэгш боломжийн төлөө залуучуудын манлайлал” сургалтын сургагч багшийг чадавхжуулах төвийн бүсийн сургалтыг НҮБ- болон Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын газартай хамтран зохион байгууллаа. Сургалтад Төв, Булган, Орхон, Дархан-Уул, Хөвсгөл аймгуудын Залуучуудын хөгжлийн төвийн 11 албан хаагч хамрагдаж “Тэгш боломжийн төлөө залуусын манлайлал” сэдвээр арга зүй өгч ажилласан.

“Бизнесийн орчинд хүүхэд хамгааллын бодлого” хэрэгжүүлэх сургалтыг Сүхбаатар, Алтанбулаг, Шаамар, Ерөө суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллагуудын удирдлагын төлөөлөл нийт 60 иргэнийг хамруулан зохион байгууллаа.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр: Аймгийн хэмжээнд 2023 оны хаврын тариалалтад 503,1 сая төгрөгийн 13 төрлийн ил талбайн болон хүлэмжийн ногооны үрийг Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны А/192 тоот тушаалаар 80 хувь хөнгөлж, 17 сум 6 тосгонд хүргүүлэн тариалалтыг хугацаанд нь хийж ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 65 аж ахуйн нэгжид үр тариа, тос, тэжээл, төмсний чиглэлээр 7,6 тэрбум төгрөг, 68 аж ахуйн нэгжид хүнсний ногоо, мөөг, жимс жимсгэнийн чиглэлээр 2,3 тэрбум төгрөг, 1 аж ахуйн нэгжид махан бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр 120 сая төгрөг, 1 аж ахуйн нэгжид гахайны аж ахуйн чиглэлээр 30 сая төгрөг, 2 аж ахуйн нэгжид зорины аж ахуй байгуулах чиглэлээр 110 сая төгрөг, 8 аж ахуйн нэгжид газар тариалангийн техник, тоног төхөөрөмж авах чиглэлээр 1 тэрбум төгрөг нийт 145 зээлдэгчид 11,3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгосон.

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран “Тариалангийн үйлдвэрлэлийн нэгдсэн систем *plant.mofa.gov.mn* программын талаар, тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсон тохиолдолд хохирол тооцох аргачлал, хөдөө аж ахуйн зохистой дадал сургалт”-ыг зохион байгуулж, 17 сумдын бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулсан.

2023 оны 05 дугаар сарын байдлаар 160.3 мянган га талбайгаас 77.7 мянган га-д үр тариа тариалалт хийгдэж, улаанбуудай 77.5 мянган га, бусад үр тариа 288 га, тосны ургамал 6.2 мянган, тэжээлийн ургамал 271 га, төмс 807 га, хүнсний ногоо 697 га талбайд тус тус тариалж, энэ хавар сэрүүхэн тариалалт оройтож хийгдэж байгаагаас шалтгаалан удаашралтай уриншийн боловсруулалт хийгдэж эхлээгүй байна.

Сумдын Хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаа болон “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоол, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй үндэсний болон аймгийн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, хаврын тариалалт, мал хаваржилтын талаарх цаг үеийн ажлыг газар дээр нь танилцаж, үнэлэлт дүгнэлт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагыг бодит мэдээллээр хангах зорилгоор зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлыг Мандал, Баянгол, Сайхан, Орхон, Сант, Алтанбулаг, Шаамар сумдад хийсэн.

Мал төллөлт, төл бойжилт хорогдлын цаг үеийн мэдээллийг 7 хоног бүр нэгтгэн аймгийн хэмжээнд 702.7 мянган толгой мал төллөж, гарсан төлөөс 28.0 мянган толгой төл хорогдож, мал төллөлт 80 хувьтай, төл бойжилт 97,7 хувьтай, хагас жилийн байдлаар нийт сүргээс 15.9 мянган толгой том мал зүй бусаар хорогдоод байна.

Аймгийн хэмжээнд зөгийн аж ахуй эрхлэгчдийн уулзалт зөвлөгөөнийг Шаамар суманд зохион байгуулж, 10 сумын 200 орчим зөгийн аж ахуй эрхлэгчдийн төлөөлөл оролцуулан зөгийн аж ахуйн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар ярилцаж цаашдын үйл ажиллагааг сайжруулах, эрх ашгийг хамгаалах зөгийчдийн холбоог үүсгэн байгуулах талаар санал солилцсон.

Бэлчээрийн тогтвортой менежмент төслийн хаалтын уулзалтыг хийж, 4 холбогдох мэргэжилтэн, малчдын төлөөлөл оролцлоо.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Байгууллага, аж ахуйн нэгжид хүүхдийн эрх ба бизнесийн зарчим, хүүхэд хамгааллын бодлогыг дэлгэрүүлэх сургалт”-ыг зочид буудал, ресторан, баар, амралтын газар, саун, барилга, уул уурхай зэрэг салбарын 60 гаруй төлөөлөл оролцуулсан зохион байгуулсан.

Мал эмнэлгийн чиглэлээр: Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны “Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай” А/19 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” А/165 дугаар захирамжийн дагуу дотрын халдварт хордлого 91.0 мянган толгой мал хамруулахаас 76.8 мянган толгой, цусан халдварт 43.0 мянган толгой үхэр хамруулахаас 5.4 мянган толгой мал, шөвөг яр 460.0 мянган бог хамруулахаас 460.0 мянган бог хамруулж, гүйцэтгэл 100 хувь буюу нийт 1.1 сая толгой мал, амьтан хамруулахаас 549.1 мянган толгой мал, амьтан хамруулж гүйцэтгэл 48.5 хувьтай байна.

Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/87-р тушаал, аймгийн Засаг даргын А/214 дүгээр захирамжаар аймгийн хэмжээнд 315.8 мянган толгой мал, амьтан хамруулахаас 295.3 мянган толгой үхэр, 7.8 мянган толгой гахай нийт 303.2 мянга буюу 96.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны “Төлөвлөгөө удирдамж батлах тухай” А/33 дугаар тушаал, аймгийн Засаг даргын “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” А/165 дугаар захирамжийн хүрээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд нийт 5.8 сая толгой мал, амьтан хамруулахаас угаалгад 1.9 сая толгой мал, амьтан хамруулахаас 289.5 мянган толгой, туулгалтад 2.0 сая толгой мал, амьтан хамруулахаас 1.4 сая толгой, боловсруулалтад 1.8 сая толгой мал, амьтан хамруулахаас 833.7 мянган толгой буюу нийт 2.5 сая толгой мал, амьтан буюу 44.0 хувийн гүйцэтгэлтэй технологит хугацаанд үргэлжилж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Эрүүл аюулгүй-Цэвэр орчин бүрдүүлэх арга хэмжээний тухай” 01 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 17 сумын Засаг даргын Тамгын газар, Мал эмнэлгийн төвтэй хамтран малын бэлчээр, зам дагуу хорогдсон, үхсэн мал, амьтны тоо, зураглалыг гарган 4.3 мянган толгой мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгал хийж, нийтийн эзэмшлийн зам талбай 7.6 мянган м2, малын хашаа, байр 27.5 мянган м2, худаг уст цэг 3.7 мянган м2, бэлчээрийн талбай 8.1 мянган м2 буюу зоорь агуулах 2.4 мянган м2, устгалын

цэгийн талбай 29.7 мянган м², нийт 88.9 мянган м² талбайд орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийсэн.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж буй мах махан бүтээгдэхүүний 5280 кг үхрийн махны 44 дээж, 90 кг адууны махны 1 дээж, 1344 кг хонины махны 64 дээж, 420 кг ямааны махны 21 дээж, 100 кг сүү, сүүн бүтээгдэхүүний 5 дээж ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийж гүйцэтгэсэн.

Зүүнбүрэн сумаас 120 арчдасын дээж, Шаамар сумаас 20 эмгэгт дээжид нян судлалын шинжилгээг хийж, Зүүнбүрэн, Сүхбаатар, Ерөө, Сант, Түшиг, Жавхлант, Хушаат, Сайхан, Баянгол сумын 879 дээжид ийлдэс судлалын шинжилгээг хийхэд Сүхбаатар сумын 1 адууны дээж, Ерөө сумын 1 адууны дээжид эсрэг бие илэрч хариуг баталгаажуулан олгосон.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр: Аймгийн Засаг даргын 2023 оны А/277 дугаар захирамжаар аймгийн хэмжээнд хаврын мод тарих ажлыг зохион байгуулж, 17 сум, 6 тосгоны 2410 иргэн, 205 аж ахуйн нэгж, байгууллага мод тарих ажилд оролцож, 7043 м² цэцгийн мандал, 1012 м² талбайд зүлэгжүүлэлт, 5,5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн, 33 нэрэмжит төгөл байгуулж, ойжуулалтыг ажлыг 117 га талбайд 288.3 мянган ширхэг тарьц, ойн зурвас 25,3 га талбайд 14.0 мянган ширхэг суулгац нийт 398.3 мянган ширхэг модыг 371.5 сая төгрөгийн зардал гарган тарьсан.

Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч, олон жил эзэнгүй орхигдсон нөхөн сэргээлт хийх шаардлагатай Ерөө сумын “Их Өлөнтийн ам” нэртэй газар “Сонортрейд” ХХК, “Цемент Шохой” ТӨХК, “Сартуул орд” ХХК, “Ди Зэт энд Ай” ХХК, “Бэрлэг майнинг” ХХК, “Илч Хужирт” ХХК, “Хандгайт гол” ХХК, “Түмэн Их Эрхэд” ХХК, “10-ын даваа” нэртэй газар “Жинжий майнинг” ХХК, Хүдэр сумын “Амж” нэртэй газар “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ТӨХК, “Энхзоо” ХХК, Баянгол сумын “Тод ундарга” ХХК, Түшиг сумын “Илч хужирт” ХХК-ууд нийт 66.5 га талбайг 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан.

2023 онд “Оюу толгой” ХХК, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгө санхүүжилтээр Ерөө сумын нутагт нийт 1025.4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхээс “Оюу толгой” ХХК-ий санхүүжилтээр 2022 онд Ерөө сумын Ялбагийн гол нэртэй газарт хийж гүйцэтгэсэн 110 га талбайн техникийн нөхөн сэргээлт, 2023 онд үлдсэн 224.7 га талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын санхүүжилтээр Ерөө сумын нутаг дэвсгэр “Харганат”, “Могойн гол” нэртэй газарт 800.7 га талбайн техникийн нөхөн сэргээлтийн эхлүүлсэн.

ОХУ-ын Буриадын Ерөнхийлөгчийн ажлын айлчлалын үеэр 60 гаруй Буриад Улсын Ойн агентлагийн ажилтан албан хаагчид, ойн аж ахуйн төлөөллийг Тужийн нарсны цамхаг, ойжуулсан талбайтай танилцуулж, 4000 ширхэг мод тарих ажлыг зохион байгуулсан.

Орхон, Орхонтуул, Сайхан сумдад хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “Ойн хүрэм” ХХК, “Тэнгэрлэг ой” ХХК-уудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, Баянгол сумын Хараа голын эрэг орчмын 5 га талбайг

бургасжуулах ажлыг гүйцэтгэх “Модны эмч” ХХК-тай гэрээ байгуулахаар мэдэгдэл хүргүүлээд байна.

Байгаль орчин аялал жуулчлалын яам, “Stream” төсөлтэй хамтран “Ойн ангийн ажилтан албан хаагчдыг чадавхжуулах сургалт”-ыг зохион байгуулж, ойн аж ахуйн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ArcGIS программыг ашиглах мэдээллийг 60 албан хаагчид олгосон.

Прокуророос харьяаллын дагуу шилжүүлсэн 1 зөрчилд хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулж Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 150.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож барагдуулсан.

Ойн тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль тогтоомж зөрчсөн 2 зөрчилд нийт 5.2 сая төгрөгийн нөхөн төлбөрийг актаар тооцож барагдуулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр: Бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлохоор хүсэлт гаргасан нөхөрлөлүүдийн талбайг Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газрын хил зааг”, 194 дүгээр тогтоол, 2015 оны “Усны сан бүхий газрын хамгаалалттай бүс” 289 дүгээр тогтоол, Байгаль орчин аялал жуулчлалын яамны ой, ус, тусгай хамгаалалттай газрын мэдээллийн сантай давхцалтай эсэхийг тогтоож холбогдох газарт хүргүүлсэн.

“Гео-Аксис” ХХК-ий гүйцэтгэсэн Улаанбаатар Төмөр замын Дохиолол холбооны 1-р ангийн Улаанбаатар Төмөр замын Хойд зөрлөгөөс Түнхэл өртөө-284 км хүртэлх төмөр замын дагуух холбооны оптик шилэн кабель, гол ба суурин холбооны кабель шугамыг 1:1000 байр зүйн зургийн мэдээллийн сан, шугам сүлжээний мэдээллийн санд тус тус бүртгэсэн.

Сүхбаатар сумын инженерийн шугам сүлжээтэй газарт нийт 114 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд: Дэд бүтцийн салбарын хяналтын газруудаас батлагдсан удирдамжийн дагуу 2023 оны 05 дугаар сарын байдлаар төлөвлөгөөт шалгалт 14 аж ахуйн нэгж, урьдчилан сэргийлэх шалгалт 16 аж ахуйн нэгж, төлөвлөгөөт бус шалгалт 10 аж ахуй нэгжийг хамруулан илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 21 аж ахуй нэгжид 130 заалттай хугацаатай албан шаардлага хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Газрын харилцаа, барилга хотын байгуулалтын салбарын улсын Ерөнхий байцаагчийн баталсан 02-00/05, 02-00/07 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Сүхбаатар, Сайхан суманд Барилгын техникийн хяналтын улсын байцаагчтай хамтарсан хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн улсын байцаагчийн хугацаатай 8 албан шаардлага өгч, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/07 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийн хавсралт хүснэгтүүдийг нэгтгэн гаргаж, хамтарсан танилцуулгыг хүргүүлж ажилласан.

Барилга хот байгуулалтын яамны салбарын Ерөнхий байцаагчийн баталсан 02-00/05, 02-00/06, 02-00/07, 02-00/08 дугаартай урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Сайхан суманд ажиллаж 2 цэцэрлэг, 2 сургууль, Сайхан сумын Засаг даргын Тамгын газар, Хот тохижилт, Сүхбаатар суманд 2 аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай 8 албан шаардлага хүргүүлсэн.

Алтанбулаг хилийн боомтын автозамын барилга байгууламж барьж буй “Эйч кэ би” ХХК, Түшиг чиглэлийн автозамын барилгын ажлыг гүйцэтгэж буй “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-уудад удирдамжийн дагуу автозамын хяналтын улсын байцаагчтай хамтарсан шалгалт хийж, илэрсэн зөрчилд хугацаатай албан шаардлага өгч, тус бүрд нь 500.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож барагдуулсан.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Монгол төр үндэсний бичиг хэрэглэсний 800 жилийн ойг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2004 онд тэмдэглэж эхэлснээс хойш өдгөө Монгол Улс 20 дахь жилдээ "Үндэсний бичиг үсэг" -ийн баярыг жил бүрийн 5 дугаар сарын эхний ням гарагт тэмдэглэж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчид, багийн иргэдийн дунд “Өртөө” тэмцээнийг ерөнхий боловсролын сургуулийн эх хэлний баг, Соёлын төв хамтран амжилттай зохион явуулж дүнгээ гаргалаа.

“Олон Улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “My family” хөгжөөнт арга хэмжээг зохион байгуулж 1,2,3 дугаар цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд ээж, аавынхаа хамт нийт 5 гэр бүл оролцлоо.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлэг зохион байгуулж, 120 иргэнийг хамрууллаа.

Аймгийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Улаан загалмайн хорооноос “Хүүхдийг зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох, эцэг эх асран хамгаалагч нарын үүрэг хариуцлагыг сайжруулах, цэцэрлэгийн багш, ажилтнуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх” зорилгоор “Замын хөдөлгөөний цагаан толгой-2023” тэмцээнд 2 дугаар цэцэрлэгийн хүүхдүүд амжилттай оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/214 тоот, сумын Засаг даргын 2023 оны А/49 тоот “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” захирамжаар “Бумбат Өлгий” мал эмнэлэг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 6000 үхэр, гахай 100 “Бөхлөө Хангай” ХХК мал эмнэлэг нь шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 177 өрхийн 6900 үхэр, 6 өрхийн 87 гахай тарьж гүйцэтгэсэн.

Тус сумын 1 дүгээр багийн 64 айлын орон сууцны дээвэр засварын ажлыг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар “Таван хан-Уул” ХХК нь 64 айлын орон сууцны 3, 4, 5, 6 дугаар байрны дээврийг бүрэн засварлаж дээврийн хучлага хар цаасыг бүрэн шинэчлэн дээврийн агааржуулалтын хоолой, яндан, хормойг хамгаалах төмрийг суурилуулж шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэв.

Аймгийн 50 сая төгрөгийн хөрөнгөөр сумын Засаг даргын Тамгын газрын дээвэр засварыг “Нарт Оргил-Өргөө” ХХК ажлыг гүйцэтгэсэн.

Бүх нийтийн мод тарилтыг сумын хэмжээнд зохион байгуулж, Улиас, Хус, Тэхийн шийг, Шар хуайс, Агч 5 төрлийн 2093 ширхэг модыг Ногоон байгууламж, Бага сургууль, Солдат 2 дугаар багийн тоглоомын талбай, Ерөнхий боловсролын сургууль, 3 дугаар цэцэрлэгийн хашаанд тарив.

“Жи Эн СИ” ХХК нь Япон Улсын хөрөнгө оруулалтаар цантахад 3,5 га талбайд 8750 ширхэг нарс модоор ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт сумын хэмжээнд 10843 ширхэг модыг тарьсан.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд 05 дугаар сарын байдлаар төллөвөл зохих нийт 68062 толгой мал байгаагаас ингэ 3, гүү 3014, үнээ 6468, эм хонь 37690, эм ямаа 20887 толгой мал төллөхөөс гүү 1808, үнээ 4200, эм хонь 33694, эм ямаа 18576 толгой нийт 58278 толгой мал төллөж төл малын хорогдол нийт 615 буюу унага 47, тугал 65, хурга 236, ишиг 267 толгой төл хорогдсон нь нийт төлийн тоотой харьцуулахад 1,06 хувийн хорогдолтой байна. Бойжиж буй төл унага 1761, тугал 4135, хурга 33458, ишиг 18309 толгой төл нийт 57663 толгой төл бойжиж байна.

Байгаль цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан малын хорогдол өмнөх жилтэй харьцуулахад 0,8 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Нийт 201071 толгой том мал буюу тэмээ 33, адуу 12660, үхэр 21148, хонь 104670, ямаа 62560 толгой мал тоологдсоноос адуу 60, үхэр 110, хонь 214, ямаа 225 нийт 609 толгой мал хорогдсон нь нийт малын 0,3 хувийг эзэлж байна.

Тус суманд 2023 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бог малын мялзан өвчний ил шинж тэмдэг илэрч Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 23-3496, 23-3504, 23-3505 тоот шинжилгээний дүнгээр сумын Бургалтай 2-р багийн нутаг Сарлагтайн ам, Хонгорморьт гэсэн хоёр газарт Бог малын мялзан өвчин илэрсэн тул сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/55 тоот захирамжаар “Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм”-ийг 21 хоногийн хугацаатай тогтоон ажиллаж байна. 05 дугаар сарын 11-ний өдрийн Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 23-3537 шинжилгээний дүнгээр дахин Бургалтай 2-р багийн нутаг Ивээлтийн өвөрт Бог малын мялзан өвчин илэрсэн тул хэсэгчилсэн хорио цээрийн дэглэмийг Ивээлтийн өвөрт 21 хоногийн хугацаатай тогтоож сумын хэмжээнд Шуурхай штаб, суурин хяналтын 3 цэг, хөдөлгөөнт 1 эргүүл, үзлэг, тандалтын багуудад сумын Онцгой комисс, төр, төсвийн байгууллагын төрийн албан хаагчид, морьт эргүүл, ойн нөхөрлөл, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн албан хаагчид, Гал унтраах, аврах 61 дүгээр ангийн албан хаагч гэсэн нийт өдөр бүр 32 албан хаагчийн давтамжтайгаар ажиллаж байна. Хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд нийт 4 өрхийн 386 толгой бог мал өвчилж 355 бог малыг устгалд оруулсан, нийт 24 өрхийн 36220 м.кв 46 хашаа хороо, 82340 м2 бэлчээр нийт 118560 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

05 дугаар сарын байдлаар сумын хэмжээнд 7500 га талбайд улаанбуудай, 20 га талбайд төмс, 4 га талбайд саримс, 3,5 га талбайд сонгино тариалж нийт тариалалт 76 хувьтай байна.

Сумын “Тариаланч, ногоочдын зөвлөгөөн-2023” арга хэмжээг газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч “Бүтлийн ундарга” ХХК-тай хамтран зохион байгуулж, тариаланч, ногоочдод цаг үеийн мэдээлэл болон газар тариалангийн цахим систем болон хүнсний улаанбуудай, хүнсний ногооны урамшуулал, хадлан бэлчээр тариалангийн талбайг хамгаалах тухай сумын Засаг даргын захирамжийн төсөл, цаг агаарын төлөв байдлын мэдээлэл, төвийн малтай айл өрхийн зохион байгуулалт, хог хаягдал, ус ашиглалтын талаарх мэдээллүүдийг танилцууллаа. Зөвлөгөөнд нийт 50 гаруй тариаланч, ногоочид оролцлоо.

Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран сумын архи, согтууруулах ундаа, тамхины зөвшөөрөлтэй 8 хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж “Тамхины тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.14 дэх

заалт”-ыг зөрчсөн 7 хүнсний дэлгүүрийн тамхины зөвшөөрлийг сумын Засаг даргын 2023 оны А/66 тоот захирамжаар хүчингүй болгож захирамжийг тухайн хүнсний дэлгүүрүүдэд танилцуулж баталгаажуулан ажиллалаа.

“Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэмцэх арга хэмжээний тухай” сумын Засаг даргын 2023 оны А/29 тоот захирамжийг батлан гаргаж захирамжийн дагуу Гамшгаас хамгаалах штабын үйл ажиллагааг тогтмолжуулж, хуурайшилтын цаг үед ажиллах морьт эргүүлүүдийг томилгоожуулан, морьт эргүүлүүдтэй шинэчилсэн гэрээ байгуулж ажиллалаа.

Сумаар дайран өнгөрөгч хот хоорондын Дархан-Эрдэнэтийн чиглэлийн автозамын дагуух болон нийтийн эзэмшлийн зам талбай, зориулалтын бус газарт хуримтлагдсан эзэнгүй хог хаягдал цэвэрлэх ажлыг 3 удаа, сэг зэм устгах ажлыг 5 удаа зохион байгуулан ажиллалаа. Бүх нийтийн их цэвэрлэгээнд төр, төсвийн 5 байгууллага, 8 аж ахуйн нэгж, 136 иргэн хамрагдаж нийтийн эзэмшлийн зам талбайн болон зориулалтын бус 3 цэгт хуримтлагдсан 12.7 тн хог хаягдлыг цэвэрлэж, хогийн нэгдсэн цэгт дарж булах ажлыг зохион байгуулсан. Мөн сумын нэгдсэн хог хаягдлын цэгийг дарж булах ажлыг зохион байгуулж, хог хаягдлын эзлэх талбайн хувь хэмжээг 2,7 га газраар бууруулан ажиллалаа.

Сэг зэм устгах ажлын хүрээнд Бургалтай 2-р багийн Ботгоны гацаанаас Хар эрэг хүртэлх газарт зүй бусаар хорогдсон 90 толгой бод, бог малыг Засаг даргын Тамгын газрын 12 албан хаагч 4 машинаар 3 өдөр ажиллаж зориулалтын нүхэнд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж булж устгасан. Мөн бог малын мялзан өвчин суманд гарсантай холбогдуулан зориудаар болон зүй бусаар хорогдсон 397 малын сэг зэмийг зориулалтын цэгт устгаж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 тоот албан даалгаврын дагуу улс, орон нутгийн чанартай автозам дагуух үйлчилгээний цэгүүдийн нүхэн жорлонг буулгах, дарж устгах үүрэг чиглэлийн хүрээнд 8 нүхэн жорлонг буулгаж, суурийг тэгшлэн ажиллалаа.

“Бид Сэлэнгийн үр сад” хүүхдийн урлагийн их наадамд Ерөнхий боловсролын сургуулиас 43 хүүхэд, 8 эцэг эх оролцоноос бага ангийн төрөлд “Эгшиглэн” хамтлаг дууны төрөлд Хүрэл медаль хүртлээ.

Сумын Улаан загалмайн хороо, Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилчидтай хамтран “Хүмүүнлэгийн өдөр”-ийг угтан сайн үйлсийн аяныг өрнүүлж 540.000 төгрөг бүхий хүнс, эд зүйлс цугларсныг зорилтот бүлгийн 2 өрхөд хандивлан дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллалаа.

Сумын Эрүүл мэндийн төвөөс 05 дугаар сард Ерөнхий боловсролын сургуулийн 510 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллалаа.

Баянгол сум:

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын санаачилсан Хамтарсан багийн гишүүдийн нийгмийн баталгаа, ажлын ачаалал зэрэгт тулгуурлан сэтгэл зүйн хямралд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт Ерөө суманд зохион байгуулагдаж хамтарсан багийн 6 гишүүн оролцлоо.

Монгол үндэсний бичиг, соёл, түүх уламжлалаа өвлүүлэх, монгол бичгийн сурталчилгааг өргөжүүлэх, монгол бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогыг дэмжих, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Засаг даргын Тамгын газар, Соёлын төв, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нартай хамтран “Хос бичигтэн Баянголчууд” арга хэмжээг зохион

байгууллаа. Арга хэмжээний хүрээнд төрийн албан хаагчид, багийн иргэдийн дунд “Цэвэр сайхан бичигтэн”, “Идэвхтэн уншигч”, “Зөв бичигтэн” уралдааныг зохион байгуулж, ЕБС-ийн дунд, ахлах ангийн суралцагчдын “Монгол уран бичлэг”-ээр үзэсгэлэн гаргаж шилдгүүдийг шалгарууллаа.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос манай аймгийн зарим сумдын төрийн албан хаагч, иргэдийн хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах, зөрчигдсөн эрхээ сэргээх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, хөдөлмөрийн харилцаа, зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилсан хандлага, арга зүйгээр явуулах арга барилд сургах зорилгоор хүний эрхийн сургалтыг зохион байгууллаа.

Орон нутгийн удирдлагуудын санаачилгаар, хүн амын шүдний өвчлөлийг бууруулах зорилгоор Т.Заманд захиралтай “Тэнгэрлэг буянтан” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Эрүүл мэндийн төвд шүдний кабинетыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангалаа.

Ахмад, Залуучуудын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор зүлэгжүүлэх талбайн хөрс арчлалт, мод тарилтын ажил явагдаж байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын баталсан “Мандал, Баянгол, Сайхан, Орхон, Сант сумдад зөвлөн туслах, шалгалт хийх” тухай удирдамжийн хүрээнд газар тариалангийн салбарын үр тариа эрхлэгч “Хос түрүү” ХХК, “Баян шинэ зам” ХХК, аж ахуй нэгжүүд, хүнсний ногоо тариалдаг “Түмэн хараа” ХХК, иргэн Д.Гантулга нарын хаврын тариалалттай газар дээр нь танилцлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд бүх нийтээр мод тарих арга хэмжээг зохион байгуулж, “Шанддов” ХХК 1200 ширхэг мод, Баян багийн 30 өрх жимсний болон гоёлын 133 мод, төр, төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчид 3600 мод тарьж сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл”-өөс сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын дунд зохион явуулж буй “Замын хөдөлгөөн цагаан толгой” тэмцээнд О.Мөнгөзул, О.Бадамханд багштай бэлтгэл бүлгийн хүүхдүүд амжилттай оролцож Тусгай байр эзэлсэн ба сурагч М.Булган-Эрдэнэ “ШИЛДЭГ ЗОХИЦУУЛАГЧ”-аар шалгарлаа.

Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Улаанбаатар хотын “Фтор дент” шүдний эмнэлэгтэй хамтран нийт 9 бүлгийн 187 хүүхдэд шүдний үзлэг хийлээ.

Олон Улсын гэр бүлийн өдөрт зориулж “Аав ээж би” өдөрлөгийг зохион байгуулж 16 эцэг эх, 8 хүүхэд идэвхтэй оролцлоо.

Ерөө сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны А/202 тоот захирамжийн хүрээнд Ерөө бүсийн аварга шалгаруулах “Дөл-2023” тэмцээнд Ерөө сумын Т.Бямбаагийн нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн “ТЭМҮҮЛЭЛ”, Хүдэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн “АЛЬФА” тасгууд хурд, хүч, авхаалж самбааг сорин уралдаж “Тэмүүлэл” баг тэргүүлж аймгийн тэмцээнд оролцлоо.

“Таныг сонсьё” арга хэмжээг Тавин, Буурагчин багийн малчдын дунд зохион байгуулж хөдөө аж ахуй, мал эмнэлэг, татвар, байгаль орчин, улсын бүртгэл, хууль

эрх зүй, эрүүл мэндийн үйлчилгээ чиглэлээр 76 өрхийн 128 иргэнд мэдээ, мэдээллийг хүргэж ажиллалаа.

2023 оны 05 дугаар сарын байдлаар нийт 24472 толгой мал төллөж, мал төллөлт 74.5 хувьтай бөгөөд гүү 450, үнээ 3720, эм хонь 11200, эм ямаа 9102 төллөөд байна.

Малын удмын сангийн үндэсний төв, НҮБ-ын “Стрийм” төсөл, Малын эрдэм шинжилгээний хүрээлэн, “Хөх үүр агро” ХХК, Мал эмнэлгийн газартай хамтран “Хариуцлагатай малчин-Хөдөө аж ахуйн сэргэлт” сургалтыг зохион 50 гаруй малчин, мал бүхий өрх хамрагдсан.

Мөн “Хуванцар савнаас татгалзъя, хүнсний зориулалтын сав, суулга хэрэглээ” уриан дор үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 58 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалж 24 төрлийн 2,580,000 төгрөгийн борлуулалтыг сумын иргэдэд хийсэн. Сургалтын үеэр сумын Засаг дарга, “Хөх үүр агро” ХХК-тай 1000 хурга нийлүүлэх санамж бичигт гарын үсэг зурсан.

Сумын Засаг даргын 2023 оны А/155 дугаар захирамжаар үржлийн малд үзлэг, ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх ажлыг зохион байгуулж Ерөө үүлдрийн хэсгийн 1500 хонь түүнээс 98 ухна, 135 хуцад үзлэг ангилалтыг хийж гүйцэтгээд байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтад сумын хэмжээнд 719 өрхийн 19725 толгой үхэр, 668 толгой гахай нийт 20393 хамрагдаад байна.

Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сумын хэмжээнд 108 өрхийн 19000 толгой богийн төл вакцинд хамруулахаар төлөвлөснөөс 35 өрхийн 7110 толгой төл малд вакцин хийгдсэн байна.

Ерөө сумын Засаг даргын 2023 оны А/141 тоот захирамжийн хүрээнд зохион байгуулагдсан YERUU CUP хурдан морины уралдаанд 3 насны ангилалд 48 морийг 27 уралдаанч хүүхэд унаж уралдлаа.

Ерөө сумын Залуучуудын нэгдлийн 5 залуучууд нэгдэн “Sunday walk” явган аялал, “Ерөө голоо хайрлая, хамгаалъя” уриатай голын эрэг дагуух хог цэвэрлэгээ, “Бяцхан зүрхэнд амьдрал бэлэглээ” хандивын аян зэрэг 3 арга хэмжээг зохион байгуулж 2,932,250 төгрөгийн хандивыг цуглуулж 35 залуучуудыг нэгтгэн цаашид хэрэгжүүлэх ажлаа төлөвлөн ажиллаж байна.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын санаачилгаар аймгийн 17 сумын Хамтарсан багийн 200 гаруй гишүүдийг чадавхжуулах, Сэтгэл зүйг дэмжих сургалт зохион байгуулагдсан.

Хоршоо хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалтаар сумын Засаг даргын 2023 оны А/137 дугаартай захирамжаар 7 иргэн, жижиг дунд бизнес эрхлэгчдэд 70,000,000 сая төгрөгийн зээлийг хоршоо хөгжүүлэх сангаас журмын дагуу олголоо.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 89 тоот тогтоолоор Төрийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 46 төрлийн ажил үйлчилгээг 4909556,6 мянган төгрөгийн өртгөөр хийгдэхээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна.

- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга байгууламж төсөл арга хэмжээний **1579548100** төгрөгийн 8 төсөл арга хэмжээнээс 6 ажил нь зарлагдаж үүнээс 5 ажил тендер шалгаруулалт явагдаж байгаа бөгөөд 1 ажил гэрээ хийгдэж хүлээн авахад бэлэн болоод байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын 1279224200 төгрөгийн 10 төсөл арга хэмжээнээс 8 ажил зарлагдаж тендер шалгаруулалтын шатанд явж байна.

- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 420170200 төгрөгийн 4 төсөл арга хэмжээнээс 4 ажил зарлагдаж үүнээс 2 ажил нь тендер шалгаруулалтын шатандаа явж байна.

- Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаар хэрэгжүүлэх зардлаас 144514000 төгрөгийн 10 төсөл ажил арга хэмжээнээс 8 ажил зарлагдаж тендер шалгаруулалтын шатандаа явж байна.

- Байгаль хамгаалах , нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр хэрэгжүүлэх 100.000,000 төгрөгийн 7 төсөл арга хэмжээний 5 ажил зарлагдан үүнээс 4 ажил гэрээ хийгдэж 1 ажил тендер шалгаруулалтынхаа явцад явж байна.

Т.Бямбаагийн нэрэмжит ерөнхий боловсролын сургууль, Улсын тэргүүний 1 дүгээр цэцэрлэгийн нийт 85 багш, ажилчдад “Объектын гал түймэр, Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр сургалт зохион байгууллаа.

Монгол Улсын Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны Мод тарих үндэсний өдөр зарлах тухай 63 дугаар зарлиг, аймгийн Засаг даргын 2023 оны А/309, сумын засаг даргын А/161 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор “БҮХ НИЙТЭЭР МОД ТАРИХ” арга хэмжээг зохион байгуулж нийтийн эзэмшлийн зам талбайд нөхөн тарилтаар 25 ширхэг нарс мод шинээр, “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГ 250 ширхэг гүйлс, голт бор зэрэг модыг тарьж усалгаа хийлээ.

Жавхлант сум:

Тариалангийн бүс нутагт бэлчээрийн даацад тохируулан суурин, хагас суурин хэлбэрээр эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх боломж нөхцөлийг хэлэлцэх, малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, Монгол Улсын Засгийн газар болон аймаг сумын мал аж ахуйн алаар баримтлан ажиллаж байгаа бодлого, зорилтыг танилцуулж мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдэх “МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨН-2023” арга хэмжээг зохион байгууллаа.

Сумын Засаг даргын захирамжийн дагуу хог цэвэрлэх сарын аяны хүрээнд “Болд Төмөр Ерөө гол”-ын Баянгол төмөр замын Цагаан хаалга өртөөний 63 албан хаагч, төр төсвийн байгууллагуудын нийт 53 албан хаагчид Шарын голын гүүрнээс 4-н зам, 4-н замаас агуут хүртэлх 27 км зам дагуу 8,7 тн хур хог хаягдлыг цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулган ажилласан.

Сумын Засаг дарга 2023 оны “Сумын нутаг дэвсгэрт Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийн талбайн хэмжээг нэмэгдүүлэх, тохижилтыг сайжруулах ажлыг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгаварт сумын төр, төсвийн байгууллагуудын дарга эрхлэгч, багийн Засаг дарга, аж ахуйн нэгж байгууллагуудын захирал, дарга, нийт иргэдэд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх жимс, жимсгэнийн мод, бутны суулгац тарихад дэмжлэг үзүүлэх, “Хашаа” хөтөлбөрийн хүрээнд Моностой 2-р багийн наадмын талбайн ойролцоох өрхүүдийн хашааг нэгэн жигд болгох ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага болон өрхүүдийн нүхэн жорлон, бохир усны цооног ариутгал, засвар үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулах, сумын төвд мал тэжээвэр амьтнаа эзэнгүй орхисноос болж ногоон байгууламж болон ойн зурваст орж мод бут, зүлэг зэргийг идэж гэмтээх, хашаа хайсыг эвдэх сүйтгэх зэрэг зөрчил сүүлийн жилүүдэд ихсэж байгаа тул эзэн

холбогдогчийг тогтоож хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож, учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, аж ахуйн нэгж, айл өрх бүр өөрийн эзэмшлийн болон нийтийн эзэмшлийн газрын орчныг тохижуулж, мод бут сөөг тарих, өнгө үзэмжид анхаарч, тодорхой цэгүүдэд шаардлага хангасан хогийн саваар хангах, ариутгал халдваргүйтгэл хийх, тариалан эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүд нь өөрийн эзэмшлийн тариалангийн талбайн захаар ойн зурвас үүсгэх, хамгаалах ажлыг эхлүүлж, цаашид жил бүр хэмжээг нэмэгдүүлэн үр дүнг тооцон мэдээлж ажиллах талаар тусгаж, цахим хуудсаар дамжуулан ард иргэд, аж ахуй нэгж байгууллагууд хүргүүлэх ажлыг зохион байгуулсан.

Зүүнбүрэн сум:

Тайлант сард сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 1 удаа хуралдаж, дараах асуудлыг хэлэлцлээ.

1. Зүүнбүрэн сум байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэх зөвшөөрөл хүсэх тухай
2. Ерөнхий боловсролын сургуулийн 100 жилийн ойг тэмдэглэх зөвшөөрөл хүсэх тухай
3. Зүүнбүрэн сум байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээг угтаж хийх ажлын төлөвлөгөө
4. Ойн нөхөрлөлүүдийн 2022 оны ажлын тайлан
5. Сумын санхүүгийн 2022 оны Аудитын дүгнэлт
6. Багийн иргэдийн Нийтийн хурлын тайланг сонсох асуудлууд

“Алсын хараа-2050” сургалтад төрийн байгууллагуудаас 12 иргэнийг сургагч багшийн цахим сургалтад хамруулсан.

Аймгийн Эрүүл мэндийн газар, сумын Эрүүл мэндийн төв сумын Засаг даргын Тамгын газрын хамтарсан гэрээний дагуу “Халуун сэтгэл” аяны хүрээнд “Хэнийг ч орхигдуулахгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бид хүргэнэ” уриатайгаар суурин 1, явуулын 2 үзлэгийн баг дотор, хүүхэд, эх барих, эмэгтэйчүүд, шүд, сэтгэц, ЭХО, ЭКГ болон сүрьеэ эрт илрүүлэлтийн үзлэг оношилгоог 1154 хүнд үйлчиллээ үзүүллээ.

“Хоггүй Зүүнбүрэнчүүд” аяны хүрээнд долоо хоногийн 5 дахь өдрийг хог цэвэрлэгээний өдөр болгон аж ахуйн нэгж байгууллага иргэдийг цэвэрлэгээнд гарган хэвшүүлээд байна.

“Тэр бум мод” хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 960 мод тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүллээ.

Хөдөө аж ахуйн үр тарианы тариалалт 75 хувьтай, төмс хүнсний ногооны тариалалт 75 хувьтай, хамгаалагдсан тариалалтад хүлэмж 15, талбайн 2100 м2 нэмэгдүүлсэн.

Мал аж ахуйн бог малын төллөлт 98 хувьтай бод малын төллөлт 89 хувь, төл 100 хувьтай бойжиж байна.

Мандал сум:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбат “Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлт талаар хэлэлцүүлгийг 370 гаруй төрийн албан хаагч, иргэдийн дунд хийж, УИХ-ын гишүүдийн тоог 152 болгоход санал 100 хувь санал нэгдээгүй тодорхой хэмжээгээр нэмэх нь зүйтэй гэдэг санал санаачилгыг иргэд гаргалаа.

Монголын олон үндэстэн, ястнуудын өвөрмөц соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, залуу үедээ өвлүүлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн

гайхамшгийг олон нийтэд таниулах, хайрлан хамгаалах зорилгоор Түнхэлд тосгонд үйл ажиллагаа явуулдаг “Түнхэл тур” амралтын газар “Монос цэцэглэх цагаар” хаврын баярын арга хэмжээг 3 өдөр зохион байгууллаа. Үйл ажиллагаанд Монгол угсаатны Буриад, Барга үндэстнүүдээс бүрдсэн 130 гаруй зочид төлөөлөгч, иргэд оролцлоо.

Аймгийн Хүний эрхийн комисстой хамтран Хүний эрхийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрхээ хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээх, урьдчилан сэргийлэх чадавхыг бий болгох, хөдөлмөрийн харилцаа, зөрчил маргаанаас урьдчилан сэргийлэх, үйл ажиллагаагаа хүний эрхэд суурилсан хандлагыг бий болгох зорилгоор зохион байгуулж буй “Хүний эрхийн тухай” сэдэвт сургалтад 10 байгууллагын 50 албан хаагчийг хамрууллаа.

Залуучуудын салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, залуус, залуучуудаасаа суралцах боломжийг бий болгох, цаашид залуучуудыг үйл ажиллагааг өргөжүүлэн тогтворжуулах, тэдний дуу хоолойг сонсож, Засгийн газар, орон нутгийн түвшин залуучуудын чиглэлээр хэрэгжиж буй бодлого шийдвэрийн талаар танилцуулах зорилгоор аймгийн Залуучуудын зөвлөлтэй хамтран “Залуучуудын чуулга уулзалт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан 320 залуусыг хамрууллаа. Залуучуудын дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд ажиллаж байгаа хүмүүст хүргэх зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн Мандал сумын Залуучуудын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгож үйл ажиллагааныхаа эхлэлийг тавилаа.

Кристина Нобелийн сангийн “Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд нөхөн үржихүйн болон бэлгийн боловсрол олгох “Сургагч багш нарыг бэлтгэх” сургалтыг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Мандал суманд зохион байгууллаа. Сургалтад Дархан-Уул, Орхон, Булган аймаг, Мандал, Баянгол сумын эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын болон хуулийн байгууллагын төлөөллүүд буюу 31 хүн сургагч багшаар бэлтгэгдлээ.

Сумын Засаг даргын 2023 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулах тухай” А/96 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор 94 нөхөрлөл, аж ахуй нэгж, албан байгууллагуудад хүргүүлэн, ойн санг гэрээгээр эзэмшдэг 23 мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагатай хурал хийж, хуурайшилтын үеийн хариуцлагын гэрээ байгууллаа. Ойн түймрээс урьдчилан сэргийлж 23 байгууллагаас хариуцлагатай жижүүр томилгоожуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Хяналтын цэгт ажиллуулах тухай” А/153 тоот захирамжийн дагуу Аргахайт, Барчулуутын нэгдсэн постод Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтсийн албан хаагчид, Түнхэл дэх Хужиртын нэгдсэн постод мод бэлтгэлийн 10 мэргэжлийн байгууллагууд хуваарийн дагуу ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны Хяналт шалгалт зохион байгуулах А/154 тоот захирамжийн дагуу аймгийн Онцгой байдлын хэлтсээс дэд даргаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн тус суманд доорх чиглэлээр ажиллалаа.

1. Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх
2. Гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн үйл ажиллагаа бэлтгэл бэлэн байдлыг үзэж шалгах

3. Төр төсвийн болон хувийн хэвшлийн гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх бэлтгэл бэлэн байдалд хяналт шалгалт хийх

4. Хуурайшилтын үеийн бэлтгэл бэлэн байдлыг шалгалаа.

Улсын төсвийн хөрөнгөөр Мандал сумын Хургалаг, Үнэглэг, Шиврийн гол, Галсанбулаг, Буянт, Тусгалт, Хуст, Бэр цагаан, Түнхэл, Баянтоого, Тарни, Бар чулуут, Дунд даваа, Шаржалга, Харчулуут, Шар шургаагт зэрэг газруудын ойн санд навч, шилмүүсний шилмүүс хуйлагч, сибирийн хүр эрвээхэй илэрч тархалттай 15000 га, голомттой 2000 га талбайг хамруулан ойн хөнөөлт шавж, өвчний судалгаа хийлээ.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийн явц, үр дүн сэдэвт зөвлөгөөнд тус сумаас мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 8 иргэн, 6 нөхөрлөл, 2 хоршоо, 21 аж ахуй нэгж байгууллага ойн ангийн нийт 55 иргэн 19 нэр төрлийн 6321 ширхэг мод, бут, сөөгийн тарьц суулгацаар идэвхтэй оролцлоо.

Сумын хэмжээнд “Хашаандаа мод тарья” аяныг өрнүүлж “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь” төслийн хүрээнд Хараа бүсийн Сум Дундын Ойн анги уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход залуучуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 600 сурагчдын дунд хашаандаа мод тарьж ургуулах уралдааныг зарлан 1200 ширхэг хайлаас, 600 сурагч бүрт 3 төрлийн 30-40 ширхэг мод, бутны үрийг хүлээлгэн өглөө.

Мөн ерөнхий боловсролын 2,3,4,5 дугаар сургуулийн ахлах ангийн 100 сурагч, анги хариуцсан багш нарыг оролцуулан “Мод үржүүлгийн газартай танилцлаа. Хүүхэд тус бүрд 30 ширхэг модны үр, 2 ширхэг хайлаас модны суулгац, 5 сургуульд 300 ширхэг хайлаасны суулгац, Мод тарих гарын авлага, хуанли, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ном зэргийг хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Ногоон Мандал” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж нийт 7 аж ахуй нэгж 3 иргэн, 4 нөхөрлөл оролцон өөрсдийн тарьж ургуулсан 19 төрлийн тарьц суулгацыг худалдан борлууллаа.

Сумын Засаг даргын 2023 оны “Малчин тариаланчдын зөрчлийг зохицуулах үүрэг бүхий” А/157 тоот захирамжийн тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орохоос урьдчилан сэргийлж ажиллаж байна.

Сумын ногоочдоо дэмжин хөдөлмөрийг нь хөнгөвчлөх, ажлын бүтээмжийг нь нэмэгдүүлэх тоног төхөөрөмжийг “Мандал шинэ агротехник” агро паркт хүлээлгэн өглөө.

Сумын хэмжээнд малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга 95 хувьтай явагдаж байна.

“Хараагийн хурд-2023” хурдан морины уралдааныг 5 насны ангиллаар зохион байгууллаа. Уралдааны үеэр хүүхдийн аюулгүй байдал хүүхдийн байгууллага хяналт тавьж ажиллаа.

Орхон сум:

Аймгийн Засаг даргын 2023 оны “Хурдан морины уралдаан зохион байгуулах тухай” А/168 тоот захирамжийн хүрээнд Буган Халиун Ажнай” Морин Спорт Уяачдын холбооны саналыг үндэслэн “Аймгийн бага нас”-ны хурдан морины уралдааныг зохион байгуулж 5 насны ангилалд 190 гаруй хурдан морь уралдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам тус суманд ажиллан “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх танилцуулга, хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулж, 45 иргэн оролцож хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой иргэдийн санал хүсэлтээ илэрхийллээ.

Бог малын гоц халдварт мялзан өвчин хөрш зэргэлдээх сумдад гарсантай холбогдуулан “Сэлэнгэ Орхон ЗДТГ” цахим хаягаар дамжуулан 5 удаагийн сэрэмжлүүлэг, санамж, зөвлөгөө хүргэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж мод тарих ногоон байгууламжийг арчлах, тэгшлэх, тайрах, цэцгийн мандал суулгац бэлтгэх ажил хийгдлээ. Нийтийн эзэмшлийн 0,2 га талбайд төр төсвийн 6 байгууллагын албан хаагчид улиас 80, хайлаас 200, үхрийн нүд 100 ширхгийг тарилаа. Мөн сумын хэмжээнд 235 айл өрх, 34 аж ахуйн нэгж, байгууллагад нарс модны 2000 ширхэг суулгацыг тараан нийт 2380 тооны мод бутыг тарилаа. Мөн 2023 онд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар тус суманд 5 га талбайд ногоон зурвас байгуулах ажлыг “Ойн хүрэм” ХХК гүйцэтгэж шинэс, агч, хайлаас, бургас зэрэг 3000 ширхэг суулгацыг тарьж хашаажуулсан байна.

Зохих зөвшөөрөлгүй 2 тооны чоно агнасан зөрчилд 150.000 төгрөгийн торгууль, 2.040.000 төгрөгийн нөхөн төлбөр, 1 тооны бор галуу агнасан зөрчилд 150.000 төгрөгийн торгууль, 116.000 төгрөгийн нөхөн төлбөр, зөвшөөрөлгүй гүний худаг гаргасан зөрчилд 150.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээг тус тус Зөрчлийн тухай хуулийн дагуу тооцсон байна.

Сумын Засаг даргын 2023 оны “Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах тухай” А/23 тоот захирамжийн дагуу Бэлэндалай багийн Гүн гууны малчид өөрсдийн санаачилгаар ойр орчмын хог цэвэрлэгээг зохион байгуулж, үхсэн малын сэг зэмийг устгаж ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын хэмжээнд 05 дугаар сарын байдлаар улаанбуудай 5104 га, овьёос 20 га, рапс 300 га, төмс 310 га, шар лууван 30 га, сонгино 20 га, сармис 8 га талбайд тус тус тариалалт хийгээд байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны “Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/214, сумын Засаг даргын “Шүлхий өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/45 тоот захирамжийн хүрээнд “Бүрэн Орхон” ХХК, “Эгдэм” БГБХН нь нийт 430 өрхийн 16100 үхэр, 100 гахайг вакцинжуулалтад хамруулаад байна.

Сумын хэмжээнд хаваржилтын төлөв байдал хэвийн явагдаж оны эхний нийт хээлтэгчийн 76.4 хувь төллөж, гарсан төлийн 77.3 буюу унага 526, тугал 3866, хурга 15403, ишиг 11484 бүгд 31279 толгой төл бойжиж байна. Том малын хорогдол 4.8 хувьтай байна.

	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Төллөсөн хээлтэгч	566	4438	19703	15754
Гарсан төл	566	4438	19703	15754
Бойжсон төл	526	3866	15403	11484
Хорогдсон төл	40	572	4300	4270
Хорогдлын хувь	7	12.8	21.8	27.1

Орхонтуул сум:

Сумын Хонгор-Овоо 3 дугаар багийн нутаг /48.92576°N, 104.70785°E/ Долоон толгой гэх газарт 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр мал амьтны гоц халдварт БММ өвчний ил шинж тэмдэг илэрсэн тухай дуудлагыг “Сэлэнгэ гранд” мал эмнэлэг хүлээн авч 2023 оны 05 дугаар сарын 10-ны 12:30 цагт газар дээр нь очиж үзлэг хийхэд малчин Т.Баасанжавын 5 хонь, 4 ямаа, 3 ишиг, 2 хурга нийт 14 толгой малын халуун 39,5-41° хүрсэн, нус, нулимс гоожсон, чацга алдсан шинж тэмдэг илэрсэн. Иргэн Т.Баасанжавын нийт 15 толгой бог малаас арчдас, нус, цусны дээжийг Улаанбаатар хотын Улсын Мал эмнэлгийн ариун цэврийн төв лабораторид хүргүүлж 2023 оны 05 дугаар сарын 11-ний 18 цаг 30 минутад 23-3538 тоот дүнгээр батлагдсан.

Тус малчны 418 толгой богт үзлэг хийхэд нийт 24 малаас шинж тэмдэг илрээд байгаа бөгөөд үхсэн 4 байна. “

Аймгийн Онцгой комиссоос өгсөн үүрэг чиглэлийн дагуу аймгийн холбогдох байгууллагын албан хаагчид манай суманд заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

“Бог малын мялзан өвчин” иргэдэд зориулсан гарын авлага бүхий боршур 120 ширхгийг хэвлэн иргэд, мал бүхий иргэдэд тараасан.

Сайхан сум:

“Хуульчийн Про Боно өдөр-2023” өдөрлөгийг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд:

- Иргэн, байгууллагад өр төлбөртэй эсэх лавлагаа, тодорхойлолт
- Монголын Өмгөөлөгчдийн Холбооны гишүүн, өмгөөлөгч Б.Даваахүүтэй хамтран иргэдэд хууль зүйн зөвлөгөө
- Засаг даргын Тамгын газар болон, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээлэл
- Эрүү, иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаарх мэдээллээр иргэдэд үйлчилгээ үзүүлсэн.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх зорилтын хүрээнд 6 бүлгийн нийт 180 хүүхэд хуваарийн дагуу өдөр тутам өглөөний дасгалыг хийж хэвшсэн. “ХӨДӨЛГӨӨН- ЭРҮҮЛ МЭНД” дасгал хөдөлгөөний тайлант өдөрлөгт 6 бүлгийн 178 хүүхэд 24 багш ажилтан оролцсон.

Сумын хэмжээнд 1082 үхэр, 4597 бог малд шүлхийгээс урьдчилан сэргийлэх тарилга, ээмэгжүүлэлт хийсэн. 05 дугаар сарын байдлаар том малын зүй бус хорогдол 26, мал төллөлт 52805 буюу 85 хувьтай явагдаж байна.

Суманд 05 дугаар сарын 22-ны өдөр бог малын “Мялзан” өвчний сэжигтэй тохиолдол илэрч Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 05 дугаар сарын 24-ний өдрийн шинжилгээгээр батлагдсантай холбогдуулан дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Иргэн Ж.Отгонбаяр, Ж.Энхбаяр нарын 2 өрхийн 163 бог малд шинж тэмдэг илэрснийг зохих дүрэм, журмын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлан устгалд оруулсан.

- “Хэсэгчилсэн хорио цээрийн дэглэм тогтоох тухай” сумын Засаг даргын захирамжийн хэрэгжилтэд нийт томилогдсон алба хаагчид хэрэгжүүлэн ажиллаж байна.
- Устгалын цэгт үүрэг гүйцэтгэх алба хаагчдад өгөх ХАБЭА зааварчилгааг өгч ажиллаж байна.
- Устгалын цэгийн Солбицол: Ө 49.25'06.7" У 105.56'29.5",
- Сумын Онцгой Комиссын хурлын шийдвэрээр Номгон 3 дугаар багийн Ухаа хошуу гэх 2 хяналтын цэгт байгуулах газар орон нутгийг үзэж байгуулахаар болсон.

2023 оны 05 дугаар сарын байдлаар 2 өрхийн 600 м2 хашаа хороо, техник, тоног төхөөрөмж, Устгалын цэгт 500 м2 талбай нийт 1100 м2 талбай ариутгасан. Устгалын цэг Солбицол: Ө 49.25'06.7" У 105.56'29.5", 2 удаагийн ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн актыг үйлдэж материалжуулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Сант сум:

Сумын хэмжээнд 49825 эх мал төллөхөөс гүү 890, үнээ 4687, эм хонь 22423, эм ямаа 14392 бүгд 42392 эх мал төллөж мал төллөлт 85 хувьтай байна. Нийт гарсан 42392 төлөөс тугал 13, хурга 45, ишиг 56, нийт 114 төл хорогдсон нь нийт төлийн 0,26 хувийг эзэлж байна.

2023 оны хаврын тариалалтын ажил эхэлж 4 аж ахуйн нэгж нийт 2519 га талбайд улаанбуудай, 1 аж ахуйн нэгж 100 га талбайд овьёос тариалсан. Төмс 38 га, хүнсний ногоо 76,6 га талбайд тус тус тариалалт хийгдсэн байна. Сумын хэмжээнд хаврын тариалалт үр тариа 65,4, төмс 19, хүнсний ногоо 51 хувьтай явагдаж байна.

“Мал эмнэлэг, эрүүл ахуй, ариутгал халдваргүйтгэлийн сарын аян”-ы хүрээнд сумын Засаг даргын 2023 оны А/50 дугаар захирамжаар сэг зэм устгалын ажил үргэлжлэн зохион байгуулагдаж Ивэн, Орхон гол дагуух ойр орчмоос 88 ширхэг малын сэг тээвэрлэж төвлөрсөн хогийн цэгт зөөсөн. Төвлөрсөн хогийн цэгт сэг зэмийг булж устгах зориулалттай нүх гаргаж 250 гаруй сэг зэм булж устган ариутгалаа. Төвлөрсөн хогийн цэгийн 240 орчим тн хогийг түрж буллаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг "Мод тарих үндэсний өдөр", "Нэг тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд төсвийн 5 байгууллага эзэмшил хашаандаа 5 төрлийн 269 ширхэг мод, халамжид хамрагдсан 8 иргэн цэцэрлэгт хүрээлэнд 8 төрлийн 260 ширхэг мод, ахмадын холбоо 2 төрлийн 421 ширхэг нийт 950 ширхэг мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлээ.

Хойд булгийн 5 га ойжуулалтын ажлыг сумын иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулан 12500 ширхэг шинэс, нэрсний суулгац таригдсан байна.

Орхон голын гүүрнээс Амарбаясгалант хийд хүрэх замыг тэмдэгжүүлэх ажлыг гүйцэтгүүлж байршууллаа.

Сант сумын харьяат асан Дамдины үр хүүхэд, ач зээ нарын санаачилгаар суманд “Баян хайрхны тахилга” арга хэмжээ зохион байгуулагдаж их нас, дааганы уралдаан явагдлаа. Сумын Засаг даргын 2023 оны өдрийн А/73 тоот захирамжаар ажлын хэсэг томилогдож унаач хүүхдүүдийн хамгаалалтын хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эцэг эхийн зөвшөөрөл авсан эсэх, хүүхдийн эрсдэлийн даатгалд хамрагдсан байдалд хяналт тавьж, уяачдад зөвлөмж, гарын авлага тарааж

ажиллалаа. Уг уралдаанд 29 их насны морьд, 15 даага уралдаж унаач хүүхэд унаж бэртэх ямар нэг эрсдэл гараагүй болно.

Сүхбаатар сүм:

Улсын хэмжээнд стратегийн команд штабын сургууль 2023 оны 6 дугаар сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгуулагдахтай холбогдуулан бэлтгэл ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны А/154 дүгээр захирамжаар томилогдсон аймгийн Онцгой байдлын газрын ажлын хэсэг тус суманд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийж, гамшгаас хамгаалах ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, Монгол Улсад мөрдөгдөж буй холбогдох эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг шалган заавар, зөвлөмж өгч, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа.

ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын тэргүүн Алексей Самбуевич Цыденов тэргүүтэй албаны төлөөлөгчид Сүхбаатар сумын Улсын тэргүүний Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуультай танилцаж, ахлах ангийн сурагчидтай уулзлаа. Уулзалтын үеэр тус сургуулийн сурагчдыг эцэг эхийн хамт Буриад улсад айлчлахыг урьж, Буриадын Их, дээд сургуулиудад үнэ төлбөргүй суралцах боломж байгааг илэрхийлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Үндэсний бичиг үсгийн өдөр”-ийг угтан Монгол бичгийн өв уламжлалаа өвлүүлэн үлдээх, сэргээн дэлгэрүүлэх хос бичигтэн болох төрийн бодлогын хэрэгжилтийг хангах, үндэсний монгол бичгийн орчин бүрдүүлэх, хүүхэд залуучууд иргэдийн монгол бичгийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сумын хэмжээнд “Би Монгол хүн” үндэсний монгол бичгийн уралдааныг зохион байгууллаа.

Уралдааны хүрээнд төр, төсвийн байгууллагуудын ажиллагсдын дунд монгол бичгийн мэдлэгийн түвшингөөс нь хамааран сургалтыг үе шаттай зохион байгуулж, сумын аж ахуй нэгж байгууллагуудын гадна хаяг, өрөө тасалгааны хаяг, лого зэргийг монгол, кирилл бичгээр бичиж, төгсөх ангийн сурагчдыг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор монгол бичгийн хичээлээс гадуурх сургалтад хамруулах, монгол бичгээр зөв цэвэр сайхан бичигтэн шалгаруулах ажлыг ерөнхий боловсролын сургууль цэцэрлэг байгууллага бүрд зохион байгууллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 5-р сургуулийн нэрэмжит “Аваргын гараа-2023” өсвөрийн үндэсний бөхийн барилдааныг аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран зохион байгууллаа. Уг тэмцээнд тус сумын ерөнхий боловсролын 1,2,5-р сургууль, Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Жавхлант, Цагааннуур, Шаамар сумдын ерөнхий боловсролын сургуулийн өсвөрийн 88 хүчит бөхчүүд зодоглож, багийн дүнгээр Зүүнбүрэн сум тэргүүн байр, Дэд байранд тус сумын ерөнхий боловсролын 5-р сургууль, Гутгаар байранд Шаамар сум, Тусгай байранд Баруунбүрэн сумын бөхчүүд шалгарлаа.

“Мэргэжил сонголт-2023” арга хэмжээний хүрээнд “Ирээдүйн 40 жилийн эзэд” “Хөтөл цемент шохой” ТӨҮГ-тай танилцах хөтөлбөрт аяллыг сумын ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн 270 гаруй хүүхдийг хамран зохион байгууллаа.

Сумын “Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн тариалан эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, зөвлөгөөнд Дархан-Уул аймгийн “Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан доктор, дэд профессор О.Нинжмаа, докторант Б.Одончимэг, магистр Д.Гантуяа, аймгийн Татварын

хэлтсийн байцаагч, Төрийн банкны эдийн засагч, “Эс Эф Си Эс” ХХК-ий гүйцэтгэх захирал Г.Ундаръяа нар оролцлоо.

Уг зөвлөгөөнөөр “Хүлэмжид хүнсний ногоо тариалах технологи”, “Жимс, жимсгэнийн тариалалтад баримтлах технологи” ургамал хамгааллын талаар, Хөдөө аж ахуйн зохистой дадал болон “Тариалангийн үйлдвэрлэлийн цахим систем”-ийн бүртгэлд хамрагдах, татварын и-баримт хэрхэн үүсгэх, арилжааны банкаар олгогдож буй хөнгөлөлттэй зээлийн талаарх мэдээллийг тариалан эрхлэгчдэд өгч “Агро парк” байгуулах талаар санал бодлоо солилцлоо.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 02 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгавар, аймгийн Засаг даргын “Бүх нийтээр мод тарих” тухай А/257 тоот захирамж, сумын Засаг даргын “Бүх нийтээр мод тарих тухай” А/182 тоот захирамжийн сумын хэмжээнд мод тарих арга хэмжээг зохион байгуулан хяналт тавин ажиллалаа.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд аймгийн Онцгой байдлын газар, “Болдтөмөр Ерөө гол” ХХК хамтран Сүхбаатар сумын Бор гүвээ 5 дугаар багт 5000 м² талбайд “Онцгой төгөл” цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг өнгөрөгч 2022 онд эхлүүлсэн. Уг бүтээн байгуулалтын ажил 3 жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд аймгийн Онцгой байдлын газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Орон нутгийн өмчийн газар, ерөнхий боловсролын 5,6 дугаар сургууль, Сүхбаатар сумын МАН-ын 8 дугаар үүр, “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ОНӨААТҮГ хамтран агч, гүйс, голт бор, хайлаас гэсэн 4 төрлийн 5000 ширхэг мод тарилаа.

Сумын Засаг даргын “Мал эмнэлэг ариун цэвэр эрүүл ахуй сэг зэм устгал ариутгал халдваргүйтгэл сарын аян зохион байгуулах тухай” А/167 тоот захирамжийн хүрээнд үхсэн малын сэг зэмийг ариутгах халдваргүйжүүлэлт хийж устгал оруулах ажлыг зохион байгуулж, Баянхан 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй “Эвсэг таван хан” бетон цутгамлын үйлдвэр нь нийгмийн хариуцлагын хүрээнд Үхэрчийн аманд 3 цаг ковш ажиллуулж сэг зэмийг хүрээг татан булшиллаа.

Сумын хэмжээнд 37 тонн сэг зэмийг устгалд оруулж Хонгорморьт 1 дүгээр баг, Баянхан 4 дүгээр баг, Боргүвээ 5 дугаар багт булшлах цэг байгуулж ажиллаж байна.

Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын санаачилгаар хэрэгжүүлж буй “Хүлэмжийн аж ахуйн агро парк байгуулах төсөл” Сүхбаатар сумын Боргүвээ 5-р багийн нутаг дэвсгэр, олон улсын зам дагуу байрлалд хэрэгжихээр болж 6×10 харьцаатай 30 хүлэмжийг гүйцэтгэгч байгууллага барих ажил эхлэхээр бэлтгэл ажил хангагдаж байна.

Түшиг сум:

Аймгийн хэмжээнд 2023 оныг “Иргэний оролцоотой цахим хөгжлийн жил” болгон зарласантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны А/61 дүгээр захирамжаар 35 ажил арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хамтарсан багийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хүчирхийлэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамтарсан багийн гишүүд цагдаагийн хэсэгтэй хамтран 24 цагийн эргүүл хяналтыг хийж байгаа бөгөөд иргэд олон нийтийг соён гэгээрүүлэх зорилготойгоор “Миний хүүхэд Монголын ирээдүй”, “Халамжаас хөдөлмөрт”, “Эрүүл Монгол хүн”, “Эрүүл шүд” аяныг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Өчигдөргүй өнөөдөр гэж үгүй” сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан “Дэвжээ” тэмцээнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын баг оролцлоо.

Малын эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээг 6 цэгт явуулж, 249 толгой сэг зэмийг булж, устгалаа.

Орон нутгийн хэмжээнд гуу жалга, гол орчмын үхсэн малын сэг зэм устгалыг ажлыг гүйцэтгүүлж, бог, бод нийт 400 гаруй сэг зэмийг булж устгалаа.

Тайлант хугацаанд сумын хэмжээнд 27142 толгой мал төллөхөөс 24150 толгой мал төллөж, нийт мал төллөлт 88,3 хувьтай байна.

Сумын дүнгээр 173 толгой мал хорогдсон бөгөөд үүнд адуу 8, үхэр 49, хонь 67, ямаа 49 байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас хөнгөлөлттэй үнээр олгогдсон нарийн ногооны үрийг 153 өрхөд тараалаа.

Үр тариа 1516 га тариалалт хийсэн бөгөөд улаанбуудай 1400 га, овьёос 116 га-д хийсэн. Төмс 17 га-д, хүнсний ногоо 13,4 га-д тариалсан.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд төв зам дагуу 200 метр хашаа барьж, 200 ширхэг модыг тарьсан.

Улаанбаатар Төмөр замын Мод боловсруулах үйлдвэр 5 дугаар сарын байдлаар өссөн дүгээр мод бэлтгэсэн ойн санд ойн нөхөн сэргээлтийн ажлыг өөрийн хөрөнгөөр 25 га-д ойжуулалт хийсэн байна.

Нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 5 дугаар сард 2 удаа зохион байгуулж, 180 га талбайд тархсан 83 м3 хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа. Мөн “Шар нарст” ХХК-ий дэмжлэгтэйгээр төв хогийн цэгийн 2,5 га талбайд тархсан 7500м3 хогийг түрж цэвэрлэлээ.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аймгийн Байгаль орчны газартай хамтран “Баруун хужир”, “Хар горхи” чиглэлийн 245 иргэн, 8 аж ахуйн нэгжид санамжийг хүргүүлээ.

Хушаат сүм:

Сумын төлийн бойжилт 05 дугаар сарын байдлаар унага 478 төлийн хорогдол 37, тугал 2779 хорогдол 86, хурга 18830 хорогдол 1202, ишиг 13723 хорогдол 1033 байна. Том малын зүй бус хорогдол адуу 23, үхэр 79, хонь 174, ямаа 234 байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 106 өрхийн 222 иргэнд анхааруулга санамж өгч ажиллалаа.

Сумын Засаг даргын захирамжийн дагуу 23 айл өрхөд мэдэгдэл өгч зам даваа гуу жалга гол булгийн эхээрх 45 сэг зэмийг цуглуулж устгалд орууллаа.

5 дугаар сарын байдлаар улаанбуудай 6889 га, тосны ургамал 2371 га, төмс 120 га, хүнсний ногоо 130 га талбайд тариалалт хийгдэж байна. Тариалангийн талбайг малаас хамгаалах тухай сумын Засаг даргын А/44 тоот захирамжийн дагуу малчин, мал бүхий иргэдийг тариалангийн талбайд мал оруулахгүй байх, малаа хариулгатай байлгах мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.

Хүдэр сүм:

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх зөвлөгөөнийг зохион байгуулж 2030 он хүртэл 17.0 мянган га талбайд 28.0 сая ширхэг мод тарьж

ургуулахаар төлөвлөн ажиллаж, өрх бүр 5 мод, байгууллага бүр 10 мод тарих уриалгыг дэвшүүлэн, уг ажлыг эрчимжүүлж ажиллах зорилт тавин ажиллаж байна.

Сумын “Малчдын зөвлөгөөн-2023” арга хэмжээ зохион байгуулагдаж төрийн байгууллагын холбогдох мэргэжилтнүүд 12 төрлийн сэдвээр илтгэл тавьж мэдээлэл өгч, орон нутгийн удирдлагууд цаг үеийн холбогдолтой мэдээлэл өгч иргэдийн санал хүсэлтийг сонсож шийдвэрлэсэн.

Сумын хэмжээнд мал бойжилтын мэдээ одоогийн байдлаар унага 894, тугал 4036, хурга 5375, ишиг 4536 нийт 14841 төл мал бойжиж нийт төллөх малын 85 хувь төллөсөн байна.

Төл мал унага 15, тугал 16, хурга 17, ишиг 17 нийт 65, том мал адуу 34, үхэр 128, хонь 116, ямаа 93 нийт 371 нийт сумын хэмжээнд 436 малын хорогдолтой байгаа нь цаг агаарын байдал хүндэрсэнтэй холбоотой байна.

Тайлангийн хугацаанд 4 аж ахуйн нэгж 3063 га талбайд тариалалт хийж үүнээс 989 га талбайд тосны ургамал, 2073 га талбайд улаан буудай, 45 га талбайд төмс, 9,5 га талбайд нарийн ногоо тус тус тариалалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт, тархалтаас урьдчилан сэргийлэх Мал Эмнэлгийн ерөнхий газрын даргын А/87 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/214, сумын засаг даргын А/44 дугаар захирамжуудын хүрээнд үхэр, гахайг яаралтай дархлаажуулах ажлыг зохион байгуулж нийт 399 өрхийн үхэр 12700 толгой, гахай 500 толгой бүгд 13200 толгой мал, амьтныг хамрууллаа.

Сумын Засаг даргын Тамгын газар Мал эмнэлгийн тасаг, “Хүдэр тохижилт” ОНӨААТҮГ хамтран өвөлжөө хаваржааны ойр орчим, нийтийн эзэмшлийн зам талбай, сумын хогын цэгт хаясан мал амьтны сэг зэм, Унаган толгойн карьерын нүхэнд хаягдсан үхрийн сэг зэмийг тус бүр цуглуулан нийт адуу 20 толгой, үхрийн сэг зэм 92, бог мал 100 толгой, нийт 212 сэг зэмийг устгал хийж халдваргүйжүүлэн ажиллалаа.

Малын гоц халдварт бог малын мялзан өвчний гаралт тархалттай холбоотой идэвхтэй тандалтын ажлыг Дулааны Энгэр, Шанд, Шивэрт, Төмөртэй, Сөдтэй, Наймын гүүрний ам, Ширүүний гармын чиглэлд, хөдөөгийн малчин 12 өрхийн суурьт эрүүл мэндийн үздэг хийж хонь 240, ямаа 270 толгой нийт 510 толгой малд үзлэг хийж халуун хэмжиж үзэхэд, сүрэгт эмгэгийн шинж тэмдэг илэрсэнгүй. Тандалтын үзлэгээр сумын малд бог малын мялзан өвчний шинж тэмдэг илрээгүй байна.

“Хүн бүр байгаль хамгаалагч” хариуцлагатай иргэн байцгаая уриатайгаар төр төсвийн байгууллагууд хамтран аянд нэгдэн арга хэмжээний хүрээнд 100 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тарааж, байгалиа хамгаалах, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн талаар сургалт хийж, мэдээ мэдээлэл хүргэн ажилласан.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Ойн газрын мэргэжилтнүүд болон Мөнх ногоон жодоо ХХК-тай хамтран Уялга, Цагаан нуга, Хүдэрийн адаг, Тээрэмт зэрэг газруудын ойн санд 14,400 га талбайд ойн хөнөөлт шавж, өвчний тандалт судалгааг хийж гүйцэтгэлээ. Судалгаагаар тухайн ойн сангийн голомтод өөрчлөлтгүй байна.

Цагааннуур сүм:

2022-2023 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэн суралцаж буй сурагчдын “ЭРДМИЙН БАЯР”-ыг тэмдэглэсэн. Энэ хичээлийн жилд сумын ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийг 3 бүлгийн 103 сурагч суралцан төгссөн.

Суманд хүнсний бараа, түүхий эдийн аюулгүй байдлыг хангуулах, хүнсээр дамжих элдэв халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Засаг даргын Тамгын газраас хяналт шалгалтын ажлын хэсэг гарч ажиллан, давхардсан тоогоор 119 нэр төрлийн /2 сая 589 мянга/ төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн лангуунаас татуулан буцаалт хийлгүүлж, 154 гаруй нэр төрлийн /5 сая 731 мянга/ төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг байгууллагын дотоод хяналтын журмын дагуу устгуулж ажилласан. Шалгалтаар 273 зөрчил илрүүлэн 244 буюу 89,3 хувийг арилгуулсан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид Улаанбаатар хотод БНСУ-ын Кёнсанбук аймгийн Уллеундо мужийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчидтэй уулзаж, гадаад хамтын ажиллагааны эхлэлийг тавилаа. Уулзалтаар цаашид ажиллах хүчний тал дээр хамтрах, хоёр орны соёл, аялал жуулчлалын салбарт харилцан туршлага солилцох бусад чиглэлээр хамтран ажиллах боломж нөхцөлийн талаар санал солилцож, сум орон нутгийн танилцуулга мэдээллийг хийсэн.

Аймгийн Засаг даргын "Бүх нийтээр мод тарих арга хэмжээ зохион байгуулах" ажлын хүрээнд 05 дугаар сард Нийтийн эдэлбэр газарт 2022 онд шинээр 6 ширхэг 3 га бичил цэцэрлэгийн хашаажуулалтыг дахин сэргээн засварлан, нарс мод 150 ширхэг, жимсний мод 40 ширхгийг Засаг даргын тамгын газар, 1-р цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль хамтран тарьсан. Сумын хэмжээнд нийт шилмүүст мод 210 ширхэг, гоёлын мод 20 ширхэг, жимсний мод 90 ширхэг буюу нийт 320 ширхэг модыг тарьсан.

Сумын хэмжээнд 5 дугаар сарын байдлаар зүй бусаар адуу 31, үхэр 217, хонь 838, ямаа 517 нийт 1603 толгой мал хорогдсон.

"Мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуй" сарын аяны хүрээнд хогийн цэг, ойр орчимд ил задгай хаясан мал, амьтны сэг зэмийг нийтлэг үйлчилгээний алба, мал эмнэлгийн тасаг хамтран устгаж, сэг зэмийн талбайг ариутгаж халдваргүйжүүлсэн. Сумын хэмжээнд үхэр 120, адуу 21, хонь 456, ямаа 321 толгой мал амьтан устгаж, малын хашаа 2400 м², худаг ус цэг 50м², устгалын цэгийн талбай 3000 м², бэлчээрийн талбай 1200 м², нийт 6650 м² талбайг халдваргүйжүүлсэн.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж, аймгийн Мал эмнэлгийн газраас хуваарилагдан ирсэн Шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг төлөвлөгөөний дагуу нийт 50000 толгой хурга ишиг хамруулж, гүйцэтгэл 100 хувьтай байна.

Сумын Засаг даргын 2023 оны А/50 тоот захирамжаар Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээнд нийт 27400 толгой үхэр, 1200 толгой гахайг 14 хоногийн хугацаанд хамруулахаар зохион байгуулж 100 хувь хамруулж дууссан.

Шаамар сум:

Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн Онцгой байдлын газрын албан хаагчид сумын Гамшгаас хамгаалах штаб, мэргэжлийн ангиудын бэлэн байдлыг шалган, туслах баг ажиллаж, сумын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийж, бэлэн байдал гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг тодотгон, 150 айл өрхүүдийн цахилгааны болон галлагааны зуух, пийшингийн аюулгүй байдалд хяналт шалгалт хийж зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг эцсийн байдлаар танилцуулах арга хэмжээг “Виктор мэт” ХХК-аас зохион байгуулж сумын нийт удирдах албан хаагчдыг хамруулсан.

“Олон Улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан Соёлын төвөөс гэр бүлүүдийн дунд “HAPPY FAMILY” хөгжөөнт тэмцээн, “Гэр бүлийн үнэ цэнэ, харилцаа” сэдэвт сургалтыг зохион байгуулж 34 өрхийн төлөөлөл оролцсон.

Сумын Засаг даргын А/56 тоот захирамжаар 2 сарын хугацаагаар Орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хэвших, хог хаягдлын тухай хууль тогтоомжийг иргэд олон нийтэд сурталчлах, мэдээлэл олгох зорилгоор “Хоггүй цэвэрхэн Шаамарчууд” аяныг зарлаж, 7 хоног бүрийн Баасан гарагийг “Бүх нийтийн цэвэрлэгээний өдөр” болгосон.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА